



ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	2
1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт	2
1.2.“Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал	2
1.4.“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулсан байдал	3
СПОРТЫН ТЭМЦЭЭН УРАЛДААН	4
БИЕИЙН ТАМИРЫН АРГА ХЭМЖЭЭ	22
1.5.Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт	67
1.6.Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	68
1.7.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн	69
1.8.Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн	70
ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	72
2.1. Байгууллагын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилт, үр дүн	72
2.2. Нийслэлийн Засаг дарга болон дүүргийн Засаг даргын хооронд байгуулсан “Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх гэрээ”-ний хэрэгжилт, үр дүн	72
2.4.Хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн, санал зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал, 2.6.Үндсэн чиг үүргийн биелэлт, үр дүнд дотоод аудит, хяналт эсвэл хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх, уг ажлын дүгнэлтийг үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлсэн байдал	74
2.7.Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал	75
2.8.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал	75
2.9.Байгууллагын үйл ажиллагаанд дотоод удирдлагын программ нэвтрүүлсэн байдал, үр дүн	75
ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ	75
3.1.Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	75
3.2.Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлтийн байдал, үр дүн	80



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт

Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу Улаанбаатар марафон, Алхацгаая - гүйцгээе хөдөлгөөн, Иргэдийн спортын Х наадам нийт 3 арга хэмжээг дүүргийн хэмжээнд зохион байгуулж 2062 багийн 92,323 иргэн хамруулсан.

1.2.“Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал

2.2.1.Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ.

- 2022 оны жилийн эцсийн байдлаар Биеийн тамирын 29 арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор 5,327 байгууллагын 190,757 иргэн хамрагдсан байна.

Биеийн тамир спортын хорооны ажилтан албан хаагчид халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, мөн дасгал хөдөлгөөнөөр эрүүлжих, дархлаажих, алхалт, гүйлтийн ач холбогдол, эрүүл хооллолт, эрүүл бие, илүүдэл жингээс урьдчилан сэргийлэх зэрэг 16 нэр төрлийн 10,000 гарын авлагыг хэвлэн иргэдэд тараасан.

2.2.2.Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлнэ.

2022 онд Үндэсний спортын **VII** их наадам улсын хэмжээнд зохион байгуулагдаж дүнгээ гаргалаа. Үндэсний спортын өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, дэмжих зорилгоор Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах “Мөсний шагайн харваа”-ны тэмцээн, “Мөсний сурын харваа”-ны тэмцээнийг зохион байгуулж нийт 37 тамирчин хурд хүч, авхаалж самбаа цэц мэргэнээ сорин өрсөлдснөөс эхний арван байрт шалгарсан тамирчид Үндэсний спортын **VII** их наадамд Баянзүрх дүүргийг төлөөлөн оролцох эрх авсан.

Монголчуудын өнө эртний түүхтэй үндэсний уламжлалт спортыг хөгжүүлэх, ёс заншил, соёлын өвийг залууст өвлүүлэх зорилгыг агуулсан Үндэсний спортын **VII** их наадмын шигшээ тэмцээнд Баянзүрх дүүргээ төлөөлөн спортын 10 төрлөөр 87 тамирчин оролцож:

Уламжлалт цуваа харвааны төрөлд 2-р байр, Буриад цуваа харвааны төрөлд 2-р байр, Шагай харваанд 3-р байр, Үзүүлэх тоглолтын төрөл, бөмбөг намнаа төрөл 2-р байр, Угтаж өнхөрч харвах төрөл, Унгар төрөл, Гранд приндпры төрлүүдэд 3-р байр, Өвлийн спортын наадам мөсний шагай, мөсний сур харваа гэсэн үндсэн 2 төрлөөр явагдсан бөгөөд Баянзүрх дүүргийн баг тамирчид мөсний шагайн харваанд 3-р байр эзэлж Байгууллагын нэгдсэн дүнгээр 4 дүгээр байрт шалгарлаа.

Баянзүрх дүүргийн Шагайн харвааны Г.Гантулга ахлагчтай баг тамирчид, болон П.Хүдэрчулуун, Б.Амарсайхан ахлагчтай Үндэсний сурын харвааны баг тамирчдын Ардын



хувьсгалын 100 жилийн их ойн баяр наадамд оролцох бэлтгэл сургуулилтыг дэмжин хамтран ажилласан.

1.4. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулсан байдал

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3 дахь “Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина”.

-НЗД-ын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3.2 заалт, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1 заалтын дагуу дүүргийн спорт цогцолборуудыг ашиглалтанд оруулна ажлын хүрээнд:

-Баянзүрх дүүргийн биеийн тамир, спорт цогцолборын барилгын явц 85%-ийн гүйцэтгэлтэй байна. 2022 онд 800.000.000 сая төгрөгийг төсөвлөж гадна тохижилтын ажил хийгдэж байна.

-НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2.5 заалт, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.5 заалтын Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг удирдлагаар ханган дэмжлэг үзүүлнэ ажлын хүрээнд:

-Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 07 дугаар сарын 06-нд батлагдан 2018 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа ба тус шинэчилсэн найруулгын дагуу дүүргийн Засаг даргын 2018 оны 02 сарын 05-ны өдрийн А/33 тоот захирамжаар Өсвөрийн шигшээ багийн тоог 12-т хүргэн шинэчлэн байгуулж үйл ажиллагааг тасралтгүй явуулж байна.

- Өсвөрийн шигшээ багийн багш дасгалжуулагчдын жилийн төлөвлөгөө, уралдаан тэмцээнд оролцох хуваарь, тухайн жилд зарцуулах төсвийн саналыг авч, батлагдсан төлөвлөгөөний дагуу бэлтгэл сургуулилтад хамруулах ажлыг зохион байгуулж нийт шигшээ багуудын нэгдсэн төлөвлөгөөг гарган батлууллаа. Өсвөрийн шигшээ багийн тоог спортын 15 төрөл болгон Засаг даргын захирамж гаргуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Өсвөр үеийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг Ширээний теннис, 100 буудалт даам, Чөлөөт бөх, Үндэсний бөхийн спортын 4 төрлөөр зохион байгуулж нийт 77 багийн 484 сурагчид хамрагдсан байна.

Өсвөрийн шигшээ багийн 12 төрөлд нийт 1000 гаруй тамирчин хүүхэд хичээллэж байгаа бөгөөд үүнээс 192 тамирчинг Дүүргийн аварга шалгаруулах тэмцээн болон бусад шатны уралдаан тэмцээнээс сонгон шалгаруулж бүртгэн авч хичээллэж байна.

Эдгээрээс: Жү-до бөх-28, Самбо бөх-23, Чөлөөт бөх-28, Бокс-13, Тэшүүр-6, Спортын гимнастик-9, Волейбол-28, Ширээний теннис-10, Даам-10, Сагсан бөмбөг-22, Буудлага-7, Байт харваа-8 нийт 192 тамирчин тус тус бэлтгэл сургуулилтад хамрагдаж байна.

-НЗД-ын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4 заалт, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2 заалтын дагуу Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагааг өргөжүүлж, нийтийг хамарсан томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ ажлын хүрээнд:

Дүүргийн хэмжээнд биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажлыг тогтмолжуулан иргэд, ажилтан албан хаагчдын бие бялдрын боловсрол, соёлыг дээшлүүлж хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэхэд мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг улам сайжруулж, тэднийг биеийн тамир, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээнд идэвхтэй оролцуулах биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөний ач холбогдол, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор Эрүүл мэндийн нэгдэлтэй хамтран дүүргийн харьяа хэлтэс албад, аж ахуйн нэгж, ЕБС, СӨББ-ын ажилтан, албан хаагчдын дунд “Эрүүл хооллолт-идэвхтэй хөдөлгөөн-эрүүл бие” 3 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 104 байгууллагын 150 хүнийг хамруулан ажиллалаа.

Төрийн болон төрийн бус байгууллагууд мөн ААН-үүдтэй хамтран ажиллаж БТСХ-ны зүгээс болон тэдгээр байгууллагуудын санаачлагаар зохион байгуулж байгаа нийтийг



хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол хүргэж байна.

-Улс орон даяар зохион байгуулагдсан “ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ- ЭРТЭЧ МОНГОЛ” аяныг 2022 оны 02 дугаар сарын 16-аас 06 дугаар сарын 01-ны өдрийг хүртэл Баянзүрх дүүргийн хэмжээнд амжилттай зохион байгуулж давхардсан тоогоор нийт **2,333** байгууллагын **45,100** ажилтан албан хаагч, багш, арга зүйч, иргэдийг хамруулж ажиллалаа.

Нийслэлийн Засаг Даргын 2022 А/546 дугаар захирамжийн дагуу “Улаанбаатар марафон” олон улсын гүйлт 7 дахь удаагаа амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. “Улаанбаатар марафон-2022” олон улсын гүйлтийн тэмцээнд Баянзүрх дүүргээс **1,684** албан хаагч, иргэд, хураамжаа төлж баталгаажилтаа хийлгэж энгэрийн номероо аван тэмцээндээ амжилттай оролцлоо.

Нийслэлийн Засаг даргын ивээл доор зохион байгуулагдаж байгаа “АЛХАЦГААЯ ГҮЙЦГЭЭ” хөдөлгөөнийг дүүрэгт зохион байгуулах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн А/177 дугаар захирамж гарч “АЛХАЦГААЯ ГҮЙЦГЭЭ” хөдөлгөөнийг дүүрэгт зохион байгуулах ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн 43 хороодын ажилтан албан хаагч иргэдийн дунд сар бүрийн 2, 4 долоо хоногийн хагас сайн өдрүүдэд явган алхалт хийх хуваарь гарган ажиллаж 2022 оны 03 дугаар сараас 11 сар хүртэл нийт **13** арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор **313** байгууллагын **25,179** иргэн хамрагдсан байна.

СПОРТЫН ТЭМЦЭЭН УРАЛДААН

-НЗД-ын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.5 заалт - “Өвлийн улиралд зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг өрөгжүүлнэ”, 2.2.2.1, 2.2.2.2 заалтууд, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3 заалт- “Спортыг дэмжих замаар өсвөрийн хүүхэд, багачуудыг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ” ажлын хүрээнд:

-Дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/74 тоот захирамжийн дагуу батлагдсан орон тооны дагуу 2022 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн Спортын хэлтэс бүрэн орон тоогоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Дүүрэгт зохион байгуулагдах тэмцээн уралдааны заавар удирдамж гаргаж, холбогдох баримт бичгийг бүрдүүлж, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, хувь хүнд хүргүүлэн мэдээ мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна.

Спортын хэлтсийн “Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г боловсруулан байгууллагын даргаар батлууллаа.

-2022 оны жилийн эцсийн байдлаар Өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн дунд дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 22 төрлөөр зохион байгуулж нийт **324** багийн **4657** тамирчин оролцсон.

Баянзүрх дүүргийн өсвөрийн шигшээ багийн тамирчид Тив дэлхийн тэмцээнээс 10, Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 26, Хотын аварга шалгаруулах тэмцээнээс 24, Нэрэмжит тэмцээнүүдээс 73 нийт 133 медаль хүртлээ .

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 2-4 жил тутамд нэг удаа зохион байгуулагддаг наадмуудад амжилт дүүрэн оролцлоо. Биеийн тамир спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын 2.1 хэсэг, Засгийн газрын 2021 оны 268 дугаар тогтоолын дагуу явагдсан Монголын бүх ард түмний спортын XV их наадамд Баянзүрх дүүргийн баг тамирчид спортын 17, паралимпын 2, дифлимпын 2 төрлөөр 200 тамирчин оролцож 49 алт, 31 мөнгө, 21 хүрэл нийт 101 медалийн эзэд болж багийн дүнгээр **Тэргүүн байр** эзэллээ.



Үндэсний спортын VII их наадамд Баянзүрх дүүргийн баг тамирчид спортын 10 төрлөөр 87 тамирчин оролцож Байгууллагын нэгдсэн дүнгээр **4 дүгээр байрт** шалгарсан амжилтыг үзүүллээ.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУЧУУДЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Баянзүрх дүүргийн Ширээний теннисний өсвөр үе, залуучуудын аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 03 дугаар сарын 12-ны өдөр эрэгтэй, эмэгтэй 4 насны ангиллаар ХУРД клуб дээр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд 12 байгууллагын өсвөр үеийн 60, залуучуудын 18 нийт 78 тамирчин өрсөлдлөө.

Шагналт байранд :

эрэгтэй

эмэгтэй

10-с доош нас

1-р байр Ханбилэг 44-р сургууль
2-р байр Төгөлдөр 30-р сургууль
3-р байр Түвшинбаяр 53-р сургууль

Энэрэл 44-р сургууль
Номин-Эрдэнэ 30-р сургууль
Цэцэглэн 44-р сургууль

11-12 нас

1-р байр Тэмүүлэн 44-р сургууль
2-р байр Энэрэлт АЦС
3-р байр Хантүшиг 92-р сургууль

Энхжин MIU
Учрал 53-р сургууль
Энэрэл 44-р сургууль

13-15 нас

1-р байр Дөлгөөн MIU
2-р байр Хосбаяр MIU
3-р байр Учралт-Од 53-р сургууль

Нандин-Эрдэнэ
Энхлэн
Наранцэцэг

16-18 нас

1-р байр Энхтөр MIU
2-р байр Билгүүдэй MIU
3-р байр Мөнх-Оргил 53-р сургууль

Батбаясгалан
Отгон
Хүслэн



“ХӨЛӨГТ ТОГЛООМ” КЛУБИЙН НЭРЭМЖИТ БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 100-Н БУУДАЛТ ДААМНЫ ӨСВӨР ҮЕИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хуулийг хэрэгжүүлэх өсвөр үеийнхний дунд 100-н буудалт даамны спортыг сурталчлах, хөгжүүлэх тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, дүүргийн өсвөрийн шигшээ багийн тамирчдыг сонгон шалгаруулж, хот, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдыг сонгон шалгаруулах зорилготойгоор “Хөлөгт тоглоом” клубын нэрэмжит Баянзүрх дүүргийн 100-н буудалт даамны өсвөр үеийн



аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 03 дугаар сарын 27-ны өдөр эрэгтэй, эмэгтэй 4 насны ангиллаар 30-р сургууль дээр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд 23 сургуулийн 136 тамирчин өрсөлдөж. Үүнээс шагналт байранд:

Эрэгтэй

Эмэгтэй

5-7 нас

- 1-р байр Ц. Билэгдэмбэрэл 48-р сургууль
- 2-р байр М. Балжир 21-р сургууль
- 3-р байр М. Тэргэл 30-р сургууль
- 4-р байр А. Содбилэг 146-р цэцэрлэг
- 5-р байр А. Түвшинсайхан 79-р сургууль

- Э. Оюунтүлхүүр ХМцэцэрлэг
- Н. Амин-Эрдэнэ 21-р сургууль
- Г. Сондор 84-р сургууль
- Х. Энх-Үжин 14-р сургууль
- Х. Нандинцэцэг 30-р сургууль

8-10 нас

- 1-р байр Г. Санчир ШМСургууль
- 2-р байр Б. Тодрол 21-р сургууль
- 3-р байр Н. Мөнх-Алдар 30-р сургууль
- 4-р байр Б. Итгэлт 21-р сургууль
- 5-р байр Б. Хангарьд ИЗсургууль

- Э. Номунзаяа Олонлог сургууль
- Б. Баянзул 21-р сургууль
- Б. Буянжаргал 21-р сургууль
- Ч. Анударь 69-р сургууль
- Б. Үржинханд 21-р сургууль

11-13 нас

- 1-р байр Л. Нямрэгзэн 21-р сургууль
- 2-р байр Э. Энх-Ирээдүй 30-р сургууль
- 3-р байр Г. Золбоо 30-р сургууль
- 4-р байр А. Баяр 44-р сургууль
- 5-р байр Б. Нямжаргал 33-р сургууль

- Ц. Цацрал 21-р сургууль
- Э. Болортунгалаг 21-р сургууль
- Ж. Есүлэн 32-р сургууль
- Э. Лхамсүрэн 30-р сургууль
- Б. Мичидмаа 30-р сургууль

14-16 нас

- 1-р байр Р. Эрхэмблэг 97-р сургууль
- 2-р байр Ц. Цолмон 84-р сургууль
- 3-р байр Б. Баярманлай ШМСургууль
- 4-р байр С. Болор 14-р сургууль
- 5-р байр Э. Эрхбаяр ШМСургууль

- Б. Анужин 69-р сургууль
- М. Энххүслэн 69-р сургууль
- Г. Марал 21-р сургууль
- Х. Марал ИЗсургууль
- Э. Цэрэнханд 53-р сургууль тус тус

шалгарч медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдаж, хотын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авлаа.

Багийн нийлбэр дүнгээр

- 1-р байр Д. Мөнхсайхан багштай 21-р сургууль
- 2-р байр Д. Амгаланбаатар багштай 30-р сургууль
- 3-р байр Их засаг сургууль тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналын эзэд боллоо.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 2022 ОНЫ “ЧӨЛӨӨТ БӨХ”-ИЙН ӨСВӨР ҮЕИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Баянзүрх дүүргийн Чөлөөт бөхийн 2022 оны өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 04 дүгээр сарын 09-ны өдөр Амгалан цогцолбор сургуулийн спорт зааланд зохион байгуулагдаж өндөрлөлөө. Өсвөр үеийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд 15 сургуулийн 148 тамирчин оролцсон.

Эмэгтэй 40 кг:

- 1.Г.Мөнхцэцэг-АЦС
- 2.М.Сарантуяа АЦС
- 3.Сарантуяа-85

43 кг:

- 1.Э.Солонго-АЦС
- 2.Г.Соёлоо-85



4.Б.Маргад-эрдэнэ-АЦС

46 кг:

- 1.Г.Сарнай-АЦС
- 2.Д.Солонго-АЦС
- 3.Мичидмма-85

- 4.Цагаандарь-85

53 кг:

- 1.Б.Ану-Үжин-АЦС
- 2.Б.Энхзул-30
- 3.Д.Хүслэн-148

- 4.М.Заяажаргал-48

61 кг:

- 1.Э.Аззаяа-АЦС
- 2.Э.Оюун-Эрдэнэ-30
- 3.Г.Ариунзаяа-30

- 4.Г.Батцэцэг-21

69 кг:

- 1.Б.Хажидмаа-АЦС
- 2.Б.Одтуяа-АЦС
- 3.Э.Халиунаа-АЦС

- 4.Т.Уянгаэрдэнэ-30

Эрэгтэй: 45 кг:

- 1.Б.Мөнхсүлд-30
- 2.О.Мөнгөншагай-Өнөрбүл
- 3.Ц.Дэлгэрсайхан- Өнөрбүл

- 4.М.Анхбаяр-АЦС

50 кг:

- 1.Наран-Өлзий-30
- 2.А.Мөнхцэрэн-АЦС
- 3.О.Сүхбат-30

- 4.Б.Тэмүүлэн-Өнөрбүл

60 кг:

- 1.А.Анхбаяр-30
- 2.Ц.Ганбат-30
- 3.Б.Мянганнасан-30

- 4.О.Амаржаргал-14

70 кг:

- 1.П.Билгүүндалай-30
- 2.Б.Жамца-АЦС
- 3.Цолмон-14

- 4.Б.Хантуул-АЦС

3.Г.Янжинлхам-АЦС

- 4.Баасанжаргал-85

49 кг:

- 1.Соёлмаа-30
- 2.М.Дэлгэрцэцэг-АЦС
- 3.П.Анужин-АЦС

- 4.Оюунчимэг-85

57 кг:

- 1.Г.Ариунбаяр-30
- 2.А.Цэцэгмаа-АЦС
- 3.Ч.Азжаргал-АЦС

- 4.А.Алтанзул-87

65 кг:

- 1.Н.Нархажид-30
- 2.О.Энхжин-АЦС
- 3.Г.Хулан-АЦС

- 4.Б.Мөнхжин-АЦС

73 кг:

- 1.О.Хулан-АЦС
- 2.М.Төгсжаргал-30
- 3.Л.Пагма-127

- 4.М.Алтан-Эрдэнэ-АЦС

47 кг:

- 1.Б.Чинзориг-87
- 2.Т.Түвшинбар-АЦС
- 3.В.Азжаргал-87

- 4.Баянбилэг-85

54 кг:

- 1.М.Сумьяабазар-53
- 2.Баточир-85
- 3.Чингүүн-85

- 4.Ц.Алтаншагай-АЦС

65 кг:

- 1.Г.Таван-Эрдэнэ-АЦС
- 2.Б.Найдангомбо-АЦС
- 3.Г.Галбадрал-30

- 4.Т.Чинболор-14

80 кг:

- 1.Э.Баярбаатар-30
- 2.Г.Дүүрэнбаяр-АЦС
- 3.У.Мөнхнаран-148

- 4.Б.Насанжаргал-30



92 кг:

- 1.Б.Чойжамц-АЦС
- 2.Д.Мөнхоргил-87
- 3.Г.Эрхэс-АЦС
- 4.Т.Буяндэлгэрэх-АЦС

110 :

- 1.Б.Анхбаяр-142
- 2.Г.Төгөлдөр-147
- 3.Э.Оч-Эрдэнэ-АЦС
- 4.Б.Амарбаясгалан-АЦС

Багийн дүнгээр:

1-р байр: Д.Гал-Эрдэнэ багштай Амгалан цогцолбор
 2-р байр: Д.Амгаланбаатар багштай 30-р сургууль
 3-р байр: Алтанзул багштай 85-р сургууль шалгарлаа. Тус тэмцээнээс шалгарсан тамирчид 2022 оны 04 дүгээр сарын 26-28-нд болох өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авлаа.



МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ СПОРТЫН XV НААДАМ

Монголын бүх ард түмний спортын XV наадмын Баянзүрх дүүргээс оролцох баг тамирчдын нэрэн мэдүүлгийг 2022 оны 03 дугаар сарын 01-ны өдөр 2022 оны 03 дугаар сарын 13-ны хооронд бүртгэж нийт 371 тамирчин цахим бүртгэлд оруулсан байна. Үүнээс 270 тамирчин анхан шатны тэмцээнээс эхний байруудад шалгарч, шигшээ тэмцээнд 201 тамирчин оролцох эрхээ авлаа. Үүнээс Дифлимп болон Паралимп төрөлд 29 тамирчин бүртгүүлсэн байна.

Баянзүрх дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/245 тоот захирамж гарч нийт 8 спортын (чөлөөт бөх, самбо бөх, сагсан бөмбөг 5x5, 3x3, волейбол, ширээний теннис, даам, шатар) төрлөөр анхан шатны тэмцээнийг дүүрэгтээ амжилттай зохион байгуулж **36** байгууллагын **258** тамирчид хамрагдсан байна.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН “САГСАН БӨМБӨГ”-ИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Биеийн тамир спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын 2.1 хэсэг, Засгийн газрын 2021 оны 268 дугаар тогтоолын дагуу Монголын бүх ард түмний спортын XV наадмын “Сагсан бөмбөг”-ийн анхан шатны тэмцээнийг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Алдар спорт хорооны зааланд амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Тэмцээний цахим бүртгэлд хамрагдсан эрэгтэй 5 багийн 60 тамирчин, эмэгтэй 4 багийн 48 тамирчин хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс Д.Цэрэнбат дасгалжуулагчтай Алдар спорт хорооны эрэгтэй, эмэгтэй багууд бүсийн тэмцээнд оролцох эрхээ авлаа.

“3x3 САГСАН БӨМБӨГ”-ИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН



Монголын бүх ард түмний спортын XV наадмын “3х3 Сагсан бөмбөг”-ийн анхан шатны тэмцээнийг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Алдар спорт хорооны зааланд амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Тэмцээний цахим бүртгэлд хамрагдсан эмэгтэй 2 багийн 24 тамирчин хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс Алдар спорт хорооны баг шигшээ тэмцээнд оролцох эрхээ авлаа.



“ШАТАР”-ЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын бүх ард түмний спортын XV наадмын “Шатар”-ын анхан шатны тэмцээнийг 2022 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр Хос мастер клуб дээр амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Тэмцээний цахим бүртгэлд хамрагдсан эрэгтэй 5 тамирчин оюун ухаан, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс Ц.Батчулуун тэргүүн байранд шалгарч шигшээ тэмцээнд оролцох эрхээ авлаа.



“ДААМ”-НЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын бүх ард түмний спортын XV наадмын “Даам”-ны анхан шатны тэмцээнийг 2022 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр “Хос мастер” клуб дээр амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Тэмцээний цахим бүртгэлд хамрагдсан эрэгтэй 4, эмэгтэй 3 тамирчин оюун ухаан, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс эрэгтэй Ганзориг, эмэгтэй Хэрлэнмөрөн нар тэргүүн байранд шалгарч шигшээ тэмцээнд оролцох эрхээ авлаа.



“ШИРЭЭНИЙ ТЕННИС”-НИЙ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын бүх ард түмний спортын XV наадмын “Ширээний теннис”-ний эрэгтэй анхан шатны тэмцээнийг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Нөхөрлөл клуб дээр



амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Тэмцээнд цахим бүртгэлд хамрагдсан эрэгтэй 10 тамирчин хурд хүч, оюун ухаан, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс ганцаарчилсан төрөлд Э. Лхагвасүрэн тэргүүн байранд шалгарч, багийн төрөлд Э. Лхагвасүрэн, Г.Ган-Эрдэнэ, Б. Буянбат нар шалгарч шигшээ тэмцээнд оролцох эрхээ авлаа.



“ЧӨЛӨӨТ БӨХ”-ИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын бүх ард түмний спортын наадмын “Чөлөөт бөх”-ийн анхан шатны тэмцээнийг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Амгалан цогцолбор сургууль дээр амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Тэмцээний цахим бүртгэлд хамрагдсан 30 тамирчин хурд хүч, оюун ухаан, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс

Эрэгтэй

- 57 кг** 1-р байр Э. Дөлөө
2-р байр А. Амарбаясгалан
3-р байр А. Оргил
3-р байр Л. Мөнхцэрэн
- 74 кг** 1-р байр Г.Ханбүргэд
2-р байр Д. Гал- Эрдэнэ
3-р байр Д. Норов- Эрдэнэ
- 57 кг** 1-р байр Э. Дөлөө
2-р байр А. Амарбаясгалан
3-р байр А. Оргил
3-р байр Л. Мөнхцэрэн

Эмэгтэй

- 50 кг** 1-р байр Б.Мөнхнаран
2-р байр П. Анужин
- 53 кг** 1-р байр Г. Отгонжаргал
- 57 кг** 1-р байр Б. Отгонтуяа
2-р байр О. Пүрэвжаргал
3-р байр Л. Цэцэгмаа

- 65 кг** 1-р байр Ц. Цогбадрах
2-р байр С. Төмөр очир
- 86 кг** 1-р байр Г. Мандахнаран
- 97 кг** 1-р байр О. Үйтүмэн
2-р байр Ю. Батсайхан
3-р байр М.Эрдэнэбат
3-р байр Ц. Бат очир
- 125 кг** 1-р байр Э. Батмагнай
2-р байр Д. Амгаланбаатар
3-р байр Х. Одгэрэл

- 62 кг** 1-р байр С. Цэрэнчимэд
2-р байр Б. Чандмань- Эрдэнэ
- 68 кг** 1-р байр Э. Даваанасан
2-р байр С. Отгончимэг
- 76 кг** 1-р байр Г. Ариунжаргал
2-р байр Г.Солонго нар шалгарч

шигшээ тэмцээнд оролцох эрхээ авлаа.





“САМБО БӨХ”-ИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын бүх ард түмний спортын XV наадмын “Самбо бөх”-ийн анхан шатны тэмцээнийг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Амгалан цогцолбор сургууль дээр амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Тэмцээний цахим бүртгэлд хамрагдсан 24 тамирчин хурд хүч, оюун ухаан, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс:

Эрэгтэй

58 кг 1-р байр Д. Алтанхуяг

64 кг 1-р байр М. Мягмардорж

71 кг 1-р байр А.Гончигжав

2-р байр Г. Билгүүн

3-р байр А. Азжаргал

+98 кг 1-р байр Х.Цогтгэрэл

Эмэгтэй

50 кг 1-р байр Г. Бүрнээбаяр

2-р байр Б. Номинзул

72 кг 1-р байр Б. Баярчимэг

2-р байр Г. Ууганчимэг

+80 кг 1-р байр Э. Жаргалмаа

2-р байр Б. Уянга нар шалгарч шигшээ тэмцээнд оролцох эрхээ авлаа.

79 кг 1-р байр Н. Балжинням

2-р байр Б. Самбууням

3-р байр П. Тэмүүжин

88 кг 1-р байр Б. Тэнгис

-98 кг 1-р байр Б. Гаажадамба

54 кг 1-р байр Ц. Гал- Од

59 кг 1-р байр Б. Хорлоо

65 кг 1-р байр А. Батзул

-80 кг 1-р байр Б. Мөнгөнтуяа

2-р байр Ц. Санжидмаа



“ВОЛЕЙБОЛ”-ЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын бүх ард түмний спортын XV наадмын “Волейбол”-ын анхан шатны тэмцээнийг 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр УСУГ-ын зааланд амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Тэмцээний цахим бүртгэлд хамрагдсан эрэгтэй 3 багийн тамирчид хурд хүч, оюун ухаан, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс:

1-р байранд БЗД-н Засаг даргын тамгын газар

2-р байранд Уурхайчин

3-р байранд Багш нарын баг тус тус шалгарч, БЗД-ийн Н.Баярсайхан дасгалжуулагчтай Уурхайчин баг шалгарч шигшээ тэмцээнд оролцох эрхээ авлаа.



ХӨНГӨН АТЛЕТИК"-ЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын бүх ард түмний спортын XV наадмын "Хөнгөн атлетик"-ын анхан шатны тэмцээнийг 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Налайх дүүргийн цэнгэлдэх хүрээлэнд амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Тэмцээний цахим бүртгэлд хамрагдсан эрэгтэй 3 багийн тамирчид хурд хүч, оюун ухаан, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс:

Эрэгтэй

- 100м 1-р байранд Г.Шижирбаатар
- 200м 1-р байранд Г.Шижирбаатар
- 400м 1-р байранд А.Бахыт
- 400м 1-р байранд А.Ахыт
- 800м 1-р байранд Д.Мягмарсүрэн
- 800м 2-р байранд Г.Одхүү
- 800м 3-р байранд А.Ахыт
- 800м 4-р байранд А.Бахыт
- 1500м 1-р байранд Д.Мягмарсүрэн
- 1500м 2-р байранд Г.Одхүү
- 5000м 1-р байранд Ц.Бямбажав
- 10000м 1-р байранд Ц.Бямбажав
- 4*100м 1-р байр Г.Шижирбаатар, А.Ахыт, А.Бахыт, Г.Одхүү, Д.Мягмарсүрэн
- 4*400м 1-р байр Г.Шижирбаатар, А.Ахыт, А.Бахыт, Г.Одхүү, Д.Мягмарсүрэн

Уртын харайлт

- 1-р байр Б.Төгөлдөр

Бөөрөнцөг түлхэлт

- 1-р байр Н.Энхгэрэл

Эмэгтэй

- 100м 1-р байр Б.Тунгалагр
- 200м 1-р байр Б.Солонго
- 200м 2-р байр Б.Тунгалаг
- 400м 1-р байр Б.Солонго
- 400м 2-р байр З.Ганхишиг
- 800м 1-р байр З.Ганхишиг
- 1500м 1-р байр Г.Хишигсайхан
- 5000м 1-р байр Б.Мөнхзаяа
- 5000м 2-р байр Г.Хишигсайхан
- 10000м 1-р байр Б.Мөнхзаяа
- 4*100м 1-р байр Б.Тунгалаг, Б.Солонго, З.Ганхишиг, Г.Анужин, Г.Хишигсайхан
- 4*400м 1-р байр Б.Тунгалаг, Б.Солонго, З.Ганхишиг, Б.Мөнхзаяа, Г.Хишигсайхан

Бөөрөнцөг түлхэлт

- 1-р байр П.Маамуу

Уртын харайлт

- 1-р байр Г.Анужин

оролцох эрхээ авлаа.

Гурвын харайлт

- 1-р байр Б.Төгөлдөр

Зээрэнцэг шидэлт

- 1-р байр Н.Энхгэрэл

Зээрэнцэг шидэлт

- 1-р байр П.Маамуу

Гурвын харайлт

- 1-р байр Г.Анужин нар шалгарч шигшээ тэмцээнд

ҮНДЭСНИЙ СПОРТЫН VII НААДАМ

Биеийн тамир спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам"-ын 2 дугаар заалтын 2.1 дэх хэсгийг



үндэслэн Монголын үндэсний спортын наадмыг зохион байгуулах зааврын дагуу зуны төрлийн тамирчдын нэрэн мэдүүлгийг авч 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн цахим бүртгэл хийгдэж үүнээс Үндэсний спортын 9 төрөл 4 үзүүлэх тоглолтын давхардсан тоогоор 141 тамирчин бүртгэлд хамрагдаад байна.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ҮНДЭСНИЙ СПОРТЫН VII ИХ НААДМЫН МӨСНИЙ ШАГАЙН ХАРВААНЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Үндэсний спортын VII их наадмын Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах “Мөсний шагайн харваа”-ны тэмцээн 2022 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр Туул голд цуваа харвааны төрлөөр амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд 12 тамирчин хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөснөөс эхний зургаан байрт шалгарсан тамирчид Үндэсний спортын VII их наадамд Баянзүрх дүүргийг төлөөлөн оролцох эрх авлаа. Шагналт байранд шалгарсан тамирчид:

1. Д. Батсайхан
2. М. Батмөнх
3. Б. Пүрэв-Очир
4. Б. Анхбаяр
5. Ш. Олзбаяр
6. З. Энхбилэг нар шалгарлаа.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ҮНДЭСНИЙ СПОРТЫН VII ИХ НААДМЫН МӨСНИЙ СУРЫН ХАРВААНЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Үндэсний спортын VII их наадмын Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах “Мөсний сурын харваа”-ны тэмцээн 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдөр Туул гол Улиастайн гүүрний зүүн захад цуваа харвааны төрлөөр амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд 25 тамирчин хурд хүч, авхаалж самбаа, цэц мэргэнээ сорин өрсөлдөснөөс эхний арван байрт шалгарсан тамирчид Үндэсний спортын VII их наадамд Баянзүрх дүүргийг төлөөлөн оролцох эрх авлаа. Тэмцээнд эхний 5 байр шалгарсан тамирчдыг өргөмжлөл медаль мөнгөн шагналаар 6-10-р байрт шалгарсан тамирчдыг өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Шагналт байранд шалгарсан тамирчид:

1. Б. Амарсайхан
2. Н. Бямбаа
3. Ж. Мөнхбат



4. Д. Ганбат
5. Л. Мөнхсайхан
6. А.Гомбодорж
7. В.Баатар
8. Д. Адъяадорж
9. Г. Ганбаатар
10. А. Баттулга нар шагналт байр эзэлж Үндэсний спортын VII их наадамд оролцох эрх авлаа.



Хотын аварга шалгаруулах Жү-до бөхийн тэмцээн

Улаанбаатар хотын Өсвөр үеийн аварга шалгаруулах "Жүдо бөхийн" тэмцээн 2022 оны 02 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд Спортын төв ордонд 2 өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд нийт 34 багийн 1000 гаруй залуу тамирчид өрсөлдсөн бөгөөд жин жингийн шилдгүүд нь Монгол Улсын Аварга шалгаруулах тэмцээний эрхийг авсан юм. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид 1 алтан медаль,



1 мөнгөн медаль хүртэж нийт 8 тамирчин Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авлаа.

Тэшүүрийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн

Гачуурт тосгонд 2022 оны 2 дугаар сарын 11-13-ны хооронд амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн өсвөрийн шигшээ багийн баг тамирчид 2 алт, 2 мөнгө, 2 хүрэл медаль хүртсэн амжилттай оролцлоо.





Хотын аварга шалгаруулах Жүдо бөхийн тэмцээн

Улаанбаатар хотын Өсвөр үеийн аварга шалгаруулах "Жүдо бөхийн" тэмцээн 2022 оны 02 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд Спортын төв ордонд 2 өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд нийт 34 багийн 1000 гаруй залуу тамирчид өрсөлдсөн бөгөөд жин жингийн шилдгүүд нь Монгол Улсын Аварга шалгаруулах тэмцээний эрхийг авсан юм. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид 1 алтан медаль,



1 мөнгөн медаль хүртэж нийт 8 тамирчин Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авлаа.

Тэшүүрийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн

Гачуурт тосгонд 2022 оны 2 дугаар сарын 11-13-ны хооронд амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн өсвөрийн шигшээ багийн баг тамирчид 2 алт, 2 мөнгө, 2 хүрэл медаль хүртсэн амжилттай оролцлоо.



Ширээний теннисний өсвөр үеийн Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн

2022 оны 03 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд Чингэлтэй дүүрэг дэх Ширээний теннисний "Оч" клубт зохион байгуулагдаж, нийт 235 тамирчид 4 насны ангиллаар ганцаарчилсан болон багийн төрөлд оролцож байна. Энэхүү тэмцээнээс багийн төрөлд эхний 4, ганцаарчилсан төрөлд эхний 7 байр эзэлсэн тамирчид 2022 оны ширээний теннисний улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авах юм. Баянзүрх дүүргийн өсвөр үеийн 24 тамирчин оролцож 4 алт, 2 мөнгө, 6 хүрэл медаль хүртсэн амжилттай оролцлоо.



Жүдо бөхийн 2022 оны өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн

2022 оны 5-р сарын 5-6-ны өдрүүдэд Улаанбаатар хот бөхийн өргөөнд амжилттай зохион байгуулагдлаа. 21 аймаг 9 дүүрэг 40 багийн 1,500 хүүхэд оролцсоноос Баянзүрх дүүргийн Жүдо бөхийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид дараах амжилтыг гаргалаа. 55кг Г.Содбилэг мөнгө, 60кг Г.Анар алт, Шагналт байр 2, багийн дүнгээр 2-р байр эзэлж амжилттай оролцлоо.



Чөлөөт бөхийн U15 улсын аварга шалгаруулах тэмцээн

Чөлөөт бөхийн U15 (өсвөр) насны ангиллын анхдугаар улсын аварга шалгаруулах тэмцээнд Д.Гал-Эрдэнэ (Амгалан цогцолбор) багштай Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх Чөлөөт бөхийн өсвөрийн шигшээ багийн тамирчид амжилттай оролцож охидын 46 кг- Г.Сарнай алт, 39 кг - М.Сарантуяа хүрэл, 36 кг- Э.Солонго хүрэл медаль хүртэж багийн дүнгээр эмэгтэй баг 5- р байрт орлоо.

Г.Сарнай нь Бахрейн улсын нийслэл Манама хотноо 2022 оны 07 дугаар сарын 01-06-ны өдрүүдэд зохиогдох U15 хүртэлх насны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд Баянзүрх дүүргээ төлөөлөн оролцохоор боллоо.



Улаанбаатар хотын Сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар лиг" сагсан бөмбөгийн шигшээ тэмцээнд Нийслэлийн 9 дүүргийн 121 сургуулийн 6,413 багийн 85,000 сурагчид оролцлоо. Тэмцээн 2022 оны 04 дүгээр сарын 20-25-ны хооронд Баянгол дүүргийн биеийн тамир, спортын хороо, Чингэлтэй дүүргийн биеийн тамир, спорт хорооны заланд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.



Баянзүрх дүүргийн 7 сургуулийн 15 баг оролцож бага насны ангилалд (эрэгтэй) Шинэ монгол сургууль тусгай байр, 33-р сургууль алтан медаль, эмэгтэй 33-р сургууль мөнгөн



медаль, дунд насны ангилалд (эрэгтэй) 33-р сургууль алтан медаль, ахлах насны ангилалд (эрэгтэй) 33-р сургууль хүрэл медаль, эмэгтэй 33-р сургууль алтан медаль авч бахдам сайхан амжилтыг үзүүллээ. Мөн бага насны эрэгтэй шилдэг дасгалжуулагчаар 33-р сургуулийн багш дасгалжуулагч Э.Бямбаа, дунд насны эрэгтэй шилдэг дасгалжуулагчаар 33-р сургуулийн багш дасгалжуулагч Н.Шижирбат, шилдэг тоглогчоор 33-р сургуулийн сурагч Хүслэн, ахлах насны эмэгтэй шилдэг дасгалжуулагчаар 33-р сургуулийн багш дасгалжуулагч Э.Болорцэцэг, шилдэг тоглогчоор 33-р сургуулийн сурагч Халиун нар тус тус шалгарлаа.

Улаанбаатар хотын Волейболын аварга шалгаруулах тэмцээн

Нийслэлийн засаг даргын нэрэмжит Улаанбаатар лиг Волейболын шигшээ тэмцээн 2022 оны 05 дугаар сарын 02-04-ны өдрүүдэд Буянт-Ухаа спортын ордонд амжилттай явагдаж өндөрлөлөө. Тэмцээнд Баянзүрх дүүргийн 5 сургуулийн 8 баг оролцож эмэгтэй дунд насны ангилалд Д.Өлзийхутаг дасгалжуулагчтай 21-р сургуулийн баг тэргүүн байр, эмэгтэй ахлах насны ангилалд 33-р сургуулийн баг шагналт 4 дүгээр байр, 21-р сургуулийн баг тэргүүн байр эзэлж амжилттай оролцлоо.



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ СПОРТЫН VII НААДМЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Үндэсний спортын VII наадам Хүй долоо худагт 2022 оны 8 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Уг наадам дөрвөн жилд нэг удаа болдог онцлогтой бөгөөд энэ жил нийт 13 төрлөөр зохиогдож байна. Үндсэн найман төрлийн спортоос гадна шинээр үзүүлэх тоглолтод морьт сурын харваа, морин дээрх барилдаан, морин өртөө уралдаан, жороо морины уралдаанууд нэмэгджээ.

Тэмцээнд 21 аймаг, есөн дүүргийн нийт 1700 орчим тамирчин оролцсон. Баяр наадмын нээлтийн ёслолд Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Д.Жаргалсайхан, Бодлого төлөвлөлтийн газрын дарга О.Гэрэл, Ерөнхий сайдын зөвлөх Я.Төмөрбаатар, ЗГХЭГ-ын референт Г.Оюунтунгалаг, Монголын үндэсний спортын хорооны ерөнхийлөгч Ц.Магалжав, Биеийн тамир спортын хорооны дарга нар оролцлоо. Мөн нээлтийн үеэр спортын бамбарыг Улсын аварга О.Хангай, даян мэргэн Б.Пунсалдулам нар бадраав.

Энэ удаагийн наадмын шигшээ тэмцээнд Баянзүрх дүүргээ төлөөлөн спортын 10 төрлөөр 87 тамирчин оролцож

Уламжлалт цуваа харвааны төрөлд

О.Энхмаа 2-р байр

Буриад цуваа харвааны төрөлд

Б.Зоригтбаатар 2-р байр

Шагай харваанд

С.Ямааранз ахлагчтай баг тамирчид 3-р байр

Үзүүлэх тоглолтын төрөлд

Б.Тэмүүжин бөмбөг намнаа төрөл 2-р байр,

Угтаж өнгөрч харвах төрөл, Унгар төрөл, Гранд приндпры төрлүүдэд

Б.Тэмүүжин 3-р байр

Монголчуудын өнө эртний түүхтэй үндэсний уламжлалт спортыг хөгжүүлэх, ёс заншил, соёлын өвийг залууст өвлүүлэх зорилгыг агуулсан Үндэсний өвлийн спортын VII наадам мөсний шагай, мөсний сур харваа гэсэн үндсэн 2 төрлөөр явагдсан бөгөөд Баянзүрх



дүүргийн баг тамирчид мөсний шагайн харваанд 3-р байр эзэлж Байгууллагын нэгдсэн дүнгээр **4 дүгээр байрт** шалгарлаа.



МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ СПОРТЫН XV НААДМЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Монголын Бүх Ард Түмний Спортын XV Наадмын шигшээ тэмцээн 2022 оны 09 дүгээр сарын 09-19-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Баянзүрх дүүргийн баг тамирчид спортын 17, паралимпын 2, дифлимпын 2 төрлөөр 200 гаруй тамирчид, багш дасгалжуулагчид, нийтдээ 220 гаруй хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо. 21 аймаг, 9 дүүргийн 4,570 орчим тамирчид 570 багц медалийн төлөө өрсөлдсөнөөс Баянзүрх дүүргийн баг тамирчид 49 алт, 31 мөнгө, 21 хүрэл нийт 101 медалийн эзэд болж багийн дүнгээр хол тасархай тэргүүлээ.





2022 ОНЫ ҮНДЭСНИЙ БӨХИЙН ӨСВӨР, ИДЭРЧҮҮДИЙН ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Баянзүрх дүүргийн Үндэсний бөхийн өсвөр үе, идэрчүүд, залуучуудын 2022 оны аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 16,17,18,19-20 насны ангиллаар 102 дугаар сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгуулагдаж дүнгээ гаргалаа.

Тус тэмцээнд 9 байгууллагын 62 тамирчин оролцлоо. Эхний 3 байрт шалгарсан тамирчин, багийг өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. 1-р байрт шалгарсан бөхчүүд Баянхонгор аймагт зохион байгуулагдах Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авлаа.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БАЙГАА БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН ДҮНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ “МӨРӨӨДЛИЙН ГООЛ 2022-2023” ХӨЛБӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН



Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулагдаж буй "Мөрөөдлийн гоол 2022-2023" хөлбөмбөгийн тэмцээн 2022 оны 10 дугаар сарын 29-нд 14-р сургуулийн гадаа талбайд эрэгтэй U-11 нас, 147-р сургуулийн гадаа талбайд эрэгтэй U-13, U-15 насны зооны тоглолтууд тус тус явагдаж өндөрлөлөө. Тэмцээнд эрэгтэй U-11 насны ангилалд

1-р байр П.Пүрэвсүрэн дасгалжуулагчтай 85-р сургууль

2-р байр Ч.Түвшинбат дасгалжуулагчтай 137-р сургууль

3-р байр Б.Эрдэнэхишиг дасгалжуулагчтай 14-р сургууль эхний 3 байрын эзэд болж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав.

Жич: 2022 оны 10 дугаар сарын 30-нд явагдах байсан эмэгтэй U-11, U-13, U-15, эрэгтэй U-13, U-15 насны шигшээ тоглолтууд цаг агаарын давагдашгүй хүчин зүйлээс болж тодорхойгүй хугацаагаар түр хойшлоод байна.



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ИВЭЭЛ ДОР ЗОХИОН БАЙГУУЛАХ “ШАТАР” СОНИРХОГЧДЫН ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монгол Улсад шинэ Үндсэн хууль баталсан өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Их хурлын даргын ивээл дор 3 үе шаттайгаар зохион байгуулагддаг шатар сонирхогчдын Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Ерөнхий боловсролын 69 дүгээр сургуулийн зааланд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тус тэмцээнд 37 хорооны эрэгтэй 74, эмэгтэй 20 тамирчин оролцож оюун ухаанаа уралдуулан өрсөлдөж дараах иргэд 2 дахь шатны тэмцээндээ оролцох эрхээ авч Монгол Улсын Их хурлын даргын гарын үсэг бүхий Талархал, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Эрэгтэй

1-р байр	Хурцгэрэл Бумбаяр	7-р хороо
2-р байр	Балсан Гантулга	17-р хороо
3-р байр	Тулгаа Золбаяр	13-р хороо
4-р байр	Шагдар Мандахнар	41-р хороо
5-р байр	Сандагдорж Сод-эрдэнэ	6-р хороо
6-р байр	Чойжин Баттогтох	5-р хороо

Эмэгтэй

1-р байр	Батхүү Энхдэлгэр	4-р хороо
2-р байр	Гэнзэнхүү Бямбарагчаа	8-р хороо
3-р байр	Жаваа Ундармаа	27-р хороо



ӨСВӨРИЙН УЛААН ЗАГАЛМАЙН ГИШҮҮДИЙН НӨХӨРСӨГ САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН

Өсвөрийн Улаан загалмайн гишүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хамтын уур амьсгалыг бий болгох, эрүүл мэнд, бие бялдрын хөгжил, спортын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Биеийн тамир спортын хороо, Баянзүрх дүүргийн улаан загалмайн хороо Bayanzurkh Red Cross хамтран нөхөрсөг сагсан бөмбөгийн тэмцээнийг 2022 оны 11 сарын 19-ны өдөр 148 дугаар сургуулийн зааланд зохион байгууллаа. Тэмцээнд 14 сургуулийн 11 эрэгтэй, 9 эмэгтэй нийт 20 баг оролцож хурд хүч, авхаалж самбаагаа сорьсноос

Шагналт байранд:

Эрэгтэй

1-р байр 33 дугаар сургууль

2-р байр 84 дүгээр сургууль

3-р байр Тэмүүжин өрлөг сургууль

Эмэгтэй

1-р байр 84 дүгээр сургууль

2-р байр 33 дугаар сургууль

3-р байр 44 дүгээр сургууль тус тус шалгарлаа.

Мөн шилдэг тоглогчоор 30 дугаар сургуулийн Р.Ринчинням, Баянзүрх цогцолбор сургуулийн Б.Маргад нар шалгарлаа.



БИЕЙН ТАМИРЫН АРГА ХЭМЖЭЭ

-НЗД-ын Засаг даргын үйл ажиллагааы хөтөлбөрийн 2.2.1.4 заалт, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааы хөтөлбөрийн 2.2.2 заалтын дагуу Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагааг өргөжүүлж, нийтийг хамарсан томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ ажлын хүрээнд:

Дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/74 тоот захирамжийн дагуу батлагдсан орон тооны дагуу 2022 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн Биеийн тамирын хэлтэс бүрэн орон тоогоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Дүүрэгт зохион байгуулагдах арга хэмжээний заавар удирдамж гаргаж, холбогдох баримт бичгийг бүрдүүлж, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, хувь хүнд хүргүүлэн мэдээ, мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна.

Биеийн тамирын хэлтсийн “Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г боловсруулан байгууллагын даргаар батлууллаа.

- 2022 оны жилийн эцсийн байдлаар Биеийн тамирын 29 арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор 5,327 байгууллагын 190,757 иргэн хамрагдсан байна. Дүүргийн хүн амын 46,9 хувийг хамруулсан байна.

-УЛСЫН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН "ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ - ЭРТЭЧ МОНГОЛ" АЯНЫ АРГА ХЭМЖЭЭ

Монгол улсын Ерөнхий сайдын санаачилгаар улс орон даяар 2022 оны 02 дугаар сарын 16-наас 05 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл амжилттай зохион байгуулагдлаа. “ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ- ЭРТЭЧ МОНГОЛ” аяны хүрээнд Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооноос дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Дүүргийн харьяа хэлтэс албад, хороод, сургууль, цэцэрлэгүүдэд аяны хугацаанд 3 чиглэлийн албан бичиг хүргүүлж албан хаагч, иргэдийг аянд идэвхтэй оролцуулах арга хэмжээ авч ажиллалаа.

“ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ - ЭРТЭЧ МОНГОЛ” АЯНЫ ХҮРЭЭНД БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН “ХӨДӨЛГӨӨН- ЭРҮҮЛ МЭНД” ӨВЛИЙН ӨДӨРЛӨГИЙН АРГА ХЭМЖЭЭ

Монгол улсын “Биеийн тамир, спортын тухай” хуулийн 10.1.5 дах заалт, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1 дэх заалт, нийслэл, дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан



сэргийлэх, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлж дадал олгох” халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, бие бялдраа чийрэгжүүлэх, биеийн дархлааг дэмжих зорилгоор дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын багш, ажилтан албан хаагчдын эрүүл мэндийг бэхжүүлэх, спортыг сурталчлах зорилгоор Баянзүрх дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дунд “ХӨДӨЛГӨӨН- ЭРҮҮЛ МЭНД” өвлийн өдөрлөгийг 2022 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Хандгайтын “Янзага” зусланд зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагаанд Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга С.Эрдэнэбат, Боловсролын хэлтсийн дарга Б.Ганбат нар арга хэмжээг нээж өдөрлөгт оролцогч багш, ажилтан албан хаагчдад амжилт хүслээ. Нээлтэнд З.Цацрал эрхлэгчтэй 22-р цэцэрлэг “Эрүүл мэндийн дасгал”, “211-р цэцэрлэг “Золбоот бүжиг”, Соёлын ордны дуучин О.Гантулга, Д.Сарантуяа эрхлэгчтэй 256-р цэцэрлэгийн хамт олон мэндчилгээ дэвшүүллээ. Өвлийн өдөрлөгийн арга хэмжээнд 49 байгууллагын 1326 багш, ажилтан албан хаагчид хамрагдлаа. Өдөрлөгийн үеэр 3 төрлийн тэмцээн явагдаж дүнгээ гаргалаа.



“ЭРЭГТЭЙ ГИР” өргөх тэмцээнд:

- 1-р байр 10 дугаар цэцэрлэгийн Д.Норовэрдэнэ
- 2-р байр 20 дугаар цэцэрлэгийн Б.Содномдаржаа
- 3-р байр 129 дүгээр цэцэрлэгийн Э.Лхагвадорж

“ЭМЭГТЭЙ ГИР” :

- 1-р байр 50 дугаар цэцэрлэгийн Н.Цэрэндолгор
- 2-р байр 82 дугаар цэцэрлэгийн Х.Эрдэнэцэцэг
- 3-р байр 203 дүгээр цэцэрлэгийн Д.Молорэрдэнэ

“ОЛС ТАТАЛТ”-ын тэмцээнд:

- 1-р байр П.Цолмон ахлагчтай 3-р цэцэрлэг
- 2-р байр Б.Пүрэвдулам ахлагчтай 129-р цэцэрлэг
- 3-р байр Ч.Чимэддорж ахлагчтай 201-р цэцэрлэг

“ХӨГЖИЛТЭЙ БУУХИА” тэмцээнд:

- 1-р байр Б.Одчимэг ахлагчтай 62-р цэцэрлэг
- 2-р байр С.Энхмөрөн ахлагчтай 20-р цэцэрлэг
- 3-р байр Д.Эрдэнэбулган ахлагчтай 52-р цэцэрлэг

ТЭМЦЭЭНИЙ НИЙЛБЭР ДҮНГЭЭР:

- 1-р байр Даваасамбуу эрхлэгчтэй 62-р цэцэрлэг
- 2-р байр Ц.Даваа эрхлэгчтэй 201-р цэцэрлэг
- 3-р байр Д.Мөнхзаяа эрхлэгчтэй 20-р цэцэрлэг нар тус тус амжилттай оролцлоо.



“ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ -ЭРТЭЧ МОНГОЛ” АЯНЫ ХҮРЭЭНД БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН “ХӨДӨЛГӨӨН- ЭРҮҮЛ МЭНД” ӨВЛИЙН ӨДӨРЛӨГИЙН АРГА ХЭМЖЭЭ



Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хороо “ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ -ЭРТЭЧ МОНГОЛ” аяны хүрээнд Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд **“ХӨДӨЛГӨӨН- ЭРҮҮЛ МЭНД”** өвлийн өдөрлөгийн арга хэмжээг **2022** оны **03** дугаар сарын **12**-ны өдөр Хандгайтын “Янзага” зусланд зохион байгууллаа. Өдөрлөгийн арга хэмжээнд **15** байгууллагын **215** багш, ажилтан албан хаагчид хамрагдлаа. Нээлтийн үйл ажиллагаанд Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга С.Эрдэнэбат, Боловсролын хэлтсийн дарга Б.Ганбат нар үг хэлж, амжилт хүслээ. Өдөрлөгийн үеэр 3 төрлийн тэмцээн явагдаж дүнгээ гаргалаа.

“ЭРЭГТЭЙ ГИР” өргөх тэмцээнд:

- 1-р байр 127-р сургуулийн Үүрцайх
- 2-р байр 102-р сургуулийн Давааням
- 3-р байр АЦСургуулийн Ганзориг

“ЭМЭГТЭЙ ГИР” :

- 1-р байр АЦСургуулийн Мөнхтуяа
- 2-р байр 155-р сургуулийн Жавхлан
- 3-р байр 102-р сургуулийн Алтаншагай

“ОЛС ТАТАЛТ” :

- 1-р байр Давааням ахлагчтай 102-р сургууль
- 2-р байр О.Хашэрдэнэ ахлагчтай 147-р сургууль
- 3-р байр М.Батзориг ахлагчтай 155-р сургууль

“ХӨГЖИЛТЭЙ БУУХИА”

- 1-р байр Б.Өнөрбаяр ахлагчтай 127-р сургууль
- 2-р байр Ж.Батсанаа ахлагчтай 102-р сургууль
- 3-р байр Э.Даваа-энхсүрэн ахлагчтай 147-р сургууль

ТЭМЦЭЭНИЙ НИЙЛБЭР ДҮНГЭЭР:

- 1-р байр Давааням ахлагчтай 102-р сургууль
- 2-р байр Б.Өнөрбаяр ахлагчтай 127-р сургууль
- 3-р байр М.Батзориг ахлагчтай 155-р сургууль нар тус тус амжилттай оролцлоо.

“ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ -ЭРТЭЧ МОНГОЛ” АЯНЫ ЯВЦЫН ШАГНАЛ ГАРДУУЛАХ ӨДӨРЛӨГИЙН АРГА ХЭМЖЭЭ

Монгол улсын Ерөнхий сайдын санаачилгаар улс орон даяар 2022 оны 02 дугаар сарын 16-наас 06 дугаар сарын 01-ны өдрийг хүртэл зохион байгуулагдаж байгаа “Илүүдэл жингүй-Эртэч монгол” аяны явцын шагнал гардуулах арга хэмжээ болон “Алхацгаая-Гүйцгээе” хөдөлгөөний нээлтийн үйл ажиллагааг 2022 оны 04 дугаар сарын 09-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, хөл бөмбөгийн талбайд амжилттай зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд :

- Засаг даргын Тамгын газар, харьяа 23-н хэлтэс, албад
- 43-н Хороодын Засаг дарга, иргэд
- Баянзүрх дүүргийн төрийн өмчийн 52 цэцэрлэг нийт 2,000 гаруй ажилтан, албан хаагчид хамрагдлаа.
- Арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтсийн дарга Б.Ганбат, Биеийн тамир, спортын хорооны дарга С.Эрдэнэбат нар үг хэллээ. Мөн ажлын байрны дасгал, “Цаглашгүй эрдэнэ бүсийн цэцэрлэгүүдийн үзүүлэх тоглолтууд явагдлаа.





“Илүүдэл жингүй-Эртэч монгол” аяны хүрээнд байгууллага хамт олноо зохион байгуулж идэвхтэй оролцсон дараах цэцэрлэгүүдийг урамшуулж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагналаа. Үүнд:

- 1-р байр Б.Даваасамбуу эрхлэгчтэй 62-р цэцэрлэг
- 2-р байр Д.Цэрэндулам эрхлэгчтэй 202-р цэцэрлэг
- 3-р байр Х. Мөнгөнтуяа эрхлэгчтэй 61-р цэцэрлэг
- 4-р байр Д.Тогтохсүрэн эрхлэгчтэй 203-р цэцэрлэг
- 5-р байр Н.Энхцэцэг эрхлэгчтэй 63-р цэцэрлэг
- 6-р байр С.Оюунгэрэл эрхлэгчтэй 169-р цэцэрлэг тус тус шалгарлаа.



“ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ МОНГОЛ” АЯНЫ ХҮРЭЭНД “ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРҮҮЛ БИЕ” ЖИН ХАСАХ УРАЛДААН

“Илүүдэл жингүй-Эртэч монгол” аяны хүрээнд “ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРҮҮЛ БИЕ” жин хасах уралдааныг 2022 оны 04 дүгээр сарын 25-наас 05 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл 1 сарын хугацаанд зохион байгуулж Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтэс албад, хороод, СӨББ, ЕБсургуулиуд нийт **23** байгууллагын **650** гаруй ажилтан, албан хаагчид хамрагдлаа. “ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРҮҮЛ БИЕ” жин хасах уралдааны хүрээнд Баянзүрх дүүргийн Усан спорт сургалтын төвтэй хамтран Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын харьяа хэлтэс албадын ажилтан, албан хаагчдыг үнэ төлбөргүйгээр Усан спорт сургалтын төвөөр үйлчлүүлэх эрх олгож урамшууллаа. Нийт 200 гаруй ажилтан, албан хаагчид хамрагдаад байна.



№	НЭРС	НАС	ХҮЙС	ӨНДӨР	ЖИН		ХАССАН ЖИН
					2022.02.18	2022.04.13	
1	Б.Даваасамбуу	34	ЭМ	188	81.4	78.4	Жирэмсэн
2	Б.Пүрэвболор	42	ЭМ	180	73	70.2	3 кг
3	С.Эрдэнэцэцэг	42	ЭМ	180	73	70.2	2.5 кг
4	М.Ариунтөвшин	35	ЭМ	155	83	80	2 кг
5	Б.Цэндийнбаян	51	ЭМ	152	86	87	1кг
6	Д.Аюуш	51	ЭМ	161	82.6	82.3	300г
7	Б.Аюуш	33	ЭМ	171	76.9	76.0	800гр
8	Э.Аюуш	27	ЭМ	150	81.8	81.4	200гр
9	Б.Болорцэцэг	50	ЭМ	185	71.8	71.4	400гр
10	Б.Аюуш	33	ЭМ	168	79.1	77.6	1.8кг
11	Б.Гэрэлтула	35	ЭМ	158	88.8	88	2.8кг
12	Б.Мөнхбаяр	29	ЭМ	180	99.8	93.3	300гр
13	Ш.Насансаргал	48	ЭМ	155	74.8	74.2	600гр
14	Б.Сүхмөр	41	ЭМ	158	88.6	83.3	2.5кг
15	М.Оюунгарал	51	ЭМ	162	87.2	87	200гр
16	Б.Сүхмөр	52	ЭМ	150	85	83.8	1.2кг
17	Б.Нанзад	35	ЭМ	153	81	80.4	800гр
18	Ж.Энхтүвшин	41	ЭМ	184	73.1	73	100гр
19	Б.Нанзад	26	ЭМ	174	109.8	102.8	4кг
20	М.Мөнхбаяр	48	ЭМ	149	84.5	84.1	400гр
21	Б.Нанзад	46	ЭМ	185	72.5	72	500гр
22	Б.Аюуш	48	ЭМ	150	80	80.6	400гр
23	Б.Баянгарал	38	ЭМ	181	87.1	86.8	600гр
24	Б.Жаргал	30	ЭМ	165	81.4	80.1	1.5кг
25	Б.Замбалгарав	30	ЭМ	165	81.4	80.1	Жирэмсэн
26	У.Увсанбаяр	55	ЭМ	160	81	80.6	400гр
27	Э.Сүхмөр	30	ЭМ	149	84.8	83.8	Жирэмсэн
28	Д.Гэрэлтүвшин	33	ЭМ	160	85	84	800гр
29	Х.Мөнхтүвшин	27	ЭМ	155	98	98	1 кг
30	Х.Мөнхтүвшин	27	ЭМ	155	98	98	1 кг

“ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ МОНГОЛ” АЯНЫ ХААЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол улсын Ерөнхий сайдын санаачилгаар улс орон даяар 2022 оны 02 дугаар сарын 16-аас 06 дугаар сарын 01-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулагдсан “Илүүдэл жингүй-Эртэч монгол” аяны хаалтыг 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 06:30 минутад улс орон даяар шууд дамжуулан хаалтын үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд Баянзүрх дүүргийн **16** СӨББайгууллагын **250** гаруй багш, ажилтан, албан хаагчид болон иргэд хамрагдлаа. Аяны нийт хугацаанд зохион байгуулсан дасгал хөдөлгөөн, сургалт, арга хэмжээнд Баянзүрх дүүргийн **2,333** байгууллагын **45,100** иргэн, ажилтан, албан хаагч, багш, арга зүйч нар давхардсан тоогоор хамрагдсан байна. Аяны хүрээнд идэвхтэй дасгал хөдөлгөөн хийсэн байгууллага, хувь хүнийг шалгаруулан Биеийн тамир спортын хорооноос шагнаж урамшууллаа.



ХАРЬЯА ХЭЛТЭС

1. И.Баттөгс даргатай Засаг даргын Тамгын газар
2. Б.Ганбат даргатай Боловсролын хэлтэс

СӨББАЙГУУЛЛАГА:

1. Б.Даваасамбуу эрхлэгчтэй 62-р цэцэрлэг
2. Х.Мөнгөнтуяа эрхлэгчтэй 61-р цэцэрлэг
3. Д.Цэрэндулам эрхлэгчтэй 202-р цэцэрлэг
4. Н.Энхцэцэг эрхлэгчтэй 63-р цэцэрлэг
5. С.Оюунгэрэл эрхлэгчтэй 169-р цэцэрлэг

ХОРООД:

1. Н.Эрдэнэзаяа засаг даргатай 21-р хороо
2. Г.Мягмардорж засаг даргатай 9-р хороо
3. М. Пүрэвдорж засаг даргатай 23-р хороо

СУРГУУЛЬ:

1. Л.Амарсанаа захиралтай 53-р сургууль
2. У.Дугармаа захиралтай 79-р сургууль
3. И.Уранбаяр захиралтай 88-р сургууль
4. Н.Энхбат захиралтай 33-р сургууль

ИРГЭД:

1. Гадийгийн Жаргалбат
2. Олонбаярын Золзаяа
3. Содовын Одсүрэн нарыг тус тус шагнаж урамшууллаа.



“УЛААНБААТАР МАРАФОН-2022” НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ШИЛЖИН ЯВАХ ЦОМЫГ БАЯНЗҮРХ ДҮҮРЭГТ АЯЛУУЛЛАА

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/546 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/196 дугаар захирамжийн дагуу “Улаанбаатар марафонд нэгдэцгээе” шилжин явах цомыг Баянзүрх дүүрэгт 04 сарын 08-наас 05 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл 48 өдөр :

1. 25-н Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтэс, албад ,
2. 43-н Хороод ,
3. 12 дээд сургууль ,
4. 35-н Ерөнхий боловсролын сургууль
5. 42 цэцэрлэг гэсэн 5 чиглэлд аялуулж байгууллага тус бүр хуваарь, төлөвлөгөө гарган ажиллаж дүүргийн хэмжээнд **172** байгууллагын **238** арга хэмжээ зохион байгуулагдан **53,180** ажилтан, албан хаагч, иргэд хамрагдсан. “Улаанбаатар марафон-2022” олон улсын гүйлтийн тэмцээнд Баянзүрх дүүргээс **1,684** албан хаагч, иргэд, энгэрийн номероо аван тэмцээндээ амжилттай оролцлоо. Үүнээс 15-н хэлтэс албад, 25



цэцэрлэг, 25-н хороод 5-н ЕБС, 5-н их дээд сургууль, 29-н төрийн бус байгууллага ubmarathon.hipay.mn марафоны сайтад 104-н албан байгууллага бүртгэлээ хийлгэж энгэрийн номер дугаараа авлаа.



“УЛААНБААТАР МАРАФОН-2022” ОЛОН УЛСЫН ГҮЙЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД БАЯНЗҮРХ ДҮҮРГЭЭС ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн Засаг Даргын 2022 А/546 дугаар захирамжийн дагуу “Улаанбаатар марафон” олон улсын гүйлт 7 дахь удаагаа амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Энэ удаагийн тэмцээний гүйлтийн онцлог нь марафонд оролцохыг хүссэн хүн бүр орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан **Hipay** аппликэйшн болон ubmarathon.hipay.mn вэб сайтаар бүртгүүлж оролцох юм. Баянзүрх дүүргийн хэмжээнд аж ахуйн нэгж, албан байгууллагуудын ажилтан, албан хаагчид, иргэд, хүүхдүүдийн дунд тэмцээн, уралдаан арга хэмжээнүүдийг зохион байгуулж нийтдээ давхардсан дүнгээр 53,180 гаруй ажилтан, албан хаагчид, оюутан сурагчид, иргэд хамрагдсан дүн мэдээтэй байна.



Баянзүрх дүүргийн иргэд “Улаанбаатар марафон-2022” олон улсын гүйлтэд олон амжилт үзүүллээ:

ЭРЭГТЭЙ 42,195 м БҮТЭН МАРАФОН

-IV байранд БЗД-ийн Алдар Спорт хорооны тамирчин Цэвээнравдан Бямбажав 00007 энгэрийн дугаартай оролцсон 2:20:37:83

ЭМЭГТЭЙ 42,195 м БҮТЭН МАРАФОН

-I байранд БЗД-ийн Алдар Спорт хорооны тамирчин Баярцогт Мөнхзаяа 00002 энгэрийн дугаартай оролцсон 2:43:46

-II байранд БЗД-ийн Алдар Спорт хорооны тамирчин Галбадрах Хишигсайхан 00011 энгэрийн дугаартай оролцсон 2:44:02

-VI байранд БЗД-ийн спорт хорооны мэргэжилтэн Намжилсүрэн Сэмжид 00178 энгэрийн дугаартай оролцсон 3:11:28



ЭРЭГТЭЙ 21,095 м 18-34 насны ангилалд

-II байранд Алдар Спорт хорооны тамирчин Гал-Эрдэнэ Одхүү 00600 энгэрийн дугаартай оролцсон 1:09:10:16

-IV байранд Алдар Спорт хорооны тамирчин Нарая Жандос 00338 энгэрийн дугаартай оролцсон 1:10:07:11

ЭМЭГТЭЙ 21,095 м 18-34 насны ангилалд

-III байранд Алдар Спорт хорооны тамирчин Чулуунхүү Шинэцэцэг 70101100 энгэрийн дугаартай оролцсон 1:26:52:70

ЭРЭГТЭЙ 21095 м 35-54 насны ангилалд

-I байранд Алдар Спорт хорооны тамирчин Асехам Бахыт 01100 энгэрийн дугаартай оролцсон 1:17:22:13

ЭРЭГТЭЙ 10000 м зайн төрөлд

-I байранд Алдар Спорт хорооны тамирчин Давааням Мягмарсүрэн 02231 энгэрийн дугаартай оролцсон 36:08:42

-II байранд Алдар Спорт хорооны тамирчин Ганцэцэг Гүррагчаа 01818 энгэрийн дугаартай оролцсон 37:31:91

ЭМЭГТЭЙ 10000 м зайн төрөлд

-I байранд Алдар Спорт хорооны тамирчин Зууннаст Ганхишиг 19402 энгэрийн дугаартай оролцсон 43:28:16

“Улаанбаатар марафон-2022” олон улсын гүйлтийн нээлтийн арга хэмжээнд Баянзүрх дүүргээс оролцож буй иргэд Санхүү Эдийн Засгийн Их сургуулийн урд талын төв замаас Дотоод Хэргийн Их сургуулийн үлээвэр найрал хөгжимчид, Баянзүрх дүүргийн Ахмад мастеруудын холбоотой хамтран 1,000 м парадаар алхаж төв талбай руу баярын жэгсаалаар алхан оролцлоо.



Нийслэлийн биеийн тамир, спортын газрын ажлын хэсгээс гаргасан хуваарийн дагуу Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хорооны 3 ажилтан, албан хаагч И-мартын уулзвар дээрх Усны цэг дээр ажиллалаа.



“Улаанбаатар марафон-2022” олон улсын гүйлтийн арга хэмжээний үеэр Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хороо Шилжин явах цомын аяны хүрээнд зохион байгуулагдсан хаалтын шагнал гардуулах үйл ажиллагааг 2022 оны 05 дугаар сарын 28-нд Монгол Бөхийн Өргөөний урд талын талбайд зохион байгууллаа. Шилжин явах цомын аяны хүрээнд дүүргийн хэмжээнд арга хэмжээ зохион байгуулж, идэвх санаачлагатай оролцсон дараах 4-н албан байгууллагуудыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.



1. Байр -Татварын хэлтэс
2. Байр - 147-р цэцэрлэг
3. Байр - Дотоод хэргийн их сургууль
4. Байр - 44-р сургууль



Хаалтын шагнал гардуулах ажиллагаанд урлаг, спортын арга хэмжээ явуулж, хөгжөөнт буухиа тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд.

1. 1-р байр Б.Гүнсэнхорол
2. 2-р байр Жагдорж
3. 3-р байр Одчимэг нар тус тус шалгарлаа.



“ХҮН АМЫН БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛ ЧИЙРЭГЖИЛТИЙН ТҮВШИН ТОГТООХ СОРИЛ”

Монгол улсын Ерөнхийлөгчийн “Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай” 2010 оны 03 дугаар сарын 26-ний өдрийн 53 дугаар зарлигийн 1 дэх заалт, Дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/250 дугаар захирамжийн хүрээнд Баянзүрх дүүрэгт Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг авлаа. Сорилд Дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийт 34 хэлтэс албад, эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төв, ЕБС, СӨББ-ын ажилтан албан хаагч, сурагчид нийт 141 байгууллагын 43324 иргэн хамрагдсан. Сорилын тайлан мэдээг нэгтгэн ЗГТА-БТСУХ, НСХ хүргүүллээ.





БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН САГСАН БӨМБӨГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ “УЛААНБААТАР –ЛИГ” ФЕСТИВАЛЬ

“Биеийн тамир, спортын тухай хууль, Нийслэл дүүргийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр, Нийслэл, дүүргийн эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэх, багийн спортоор дамжуулж өсвөр үеийнхний бие бялдрыг хөгжүүлэх, хамтач үзэл санааг төлөвшүүлэх, спортоор хичээллэх хүсэл сонирхлыг бий болгох зорилгоор Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Улаанбаатар-лиг” сагсан бөмбөгийн фестивалийг 2022 оны 04 дугаар сарын 04-08-ны хооронд бага, дунд, ахлах 3-н насны ангиллаар 14, 155, 33, 147, 48, Амгалан цогцолбор сургуулиудад амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд нийт 110 багийн 1,500 тамирчин оролцлоо.

БАГА НАСНЫ АНГИЛАЛД:

ЭРЭГТЭЙ:

1-р байр П.Пүрэвсүрэн дасгалжуулагчтай 85-р сургууль

2-р байр Э. Бямбаа дасгалжуулагчтай 33-р сургууль

3-р байр Д.Эрдэнэ-Очир дасгалжуулагчтай ШИНэ Монгол сургууль

ЭМЭГТЭЙ:

1-р байр Э. Болорцэцэг дасгалжуулагчтай 33-р сургууль

2-р байр П.Жавзанпагма дасгалжуулагчтай 84-р сургууль

3-р байр М.Мөнхзул дасгалжуулагчтай 120-р сургууль

ДУНД НАСНЫ АНГИЛАЛД:

ЭРЭГТЭЙ:

1-р байр Н.Шижирбат дасгалжуулагчтай 33-р сургууль

2-р байр Б.Бямбасүрэн дасгалжуулагчтай 133-р сургууль

3-р байр Л.Отгонцэрэн дасгалжуулагчтай 97-р сургууль

ЭМЭГТЭЙ:

1-р байр Э.Болорцэцэг дасгалжуулагчтай 33-р сургууль

2-р байр Р.Төгссайхан дасгалжуулагчтай 30-р сургууль

3-р байр Я.Эрдэнэдолгор дасгалжуулагчтай 44-р сургууль

АХЛАХ НАСНЫ АНГИЛАЛД:

ЭРЭГТЭЙ:

1-р байр Отгонжаргал дасгалжуулагчтай 84-р сургууль

2-р байр Н.Шижирбат дасгалжуулагчтай 33-р сургууль

3-р байр Ц.Даваадорж дасгалжуулагчтай ЭМ АЙ Ю сургууль

ЭМЭГТЭЙ:

1-р байр Болорцэцэг дасгалжуулагчтай 33-р сургууль

2-р байр П.Жавзанпагма дасгалжуулагчтай 84-р сургууль

3-р байр Р.Төгссайхан дасгалжуулагчтай 30-р сургууль тус тус шалгарлаа.





БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ВОЛЕЙБОЛЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ “УЛААНБААТАР –ЛИГ” ФЕСТИВАЛЬ

Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Улаанбаатар-лиг” волейболын фестивалийг 2022 оны 03 дугаар сарын 26-наас 03 дугаар сарын 27-ны өдрүүдэд 2 насны ангиллаар 2 өдрийн турш амжилттай зохион байгууллаа. Нийт 31 багийн 741 тамирчин оролцлоо.

Ахлах насны эрэгтэй

1-р байр 21-р сургууль
2-р байр 97-р сургууль
3-р байр 102-р сургууль

Ахлах насны эмэгтэй

1-р байр 21-р сургууль
2-р байр 33-р сургууль
3-р байр 84-р сургууль

Дунд насны эрэгтэй

1-р байр 21-р сургууль
2-р байр гёте сургууль
3-р байр 44-р сургууль

Дунд насны эмэгтэй

1-р байр 21-р сургууль
2-р байр 97-р сургууль
3-р байр 44-р сургууль тус тус шагналт байр эзэллээ.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН УРАН ХӨДӨЛГӨӨНТ ГИМНАСТИКИЙН АРГА ХЭМЖЭЭ

Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах цэцэрлэгийн хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээн 2022 оны 04 дүгээр сарын 26-нд Монгол бөхийн өргөөнд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээний нээлтийн үйл ажиллагааг Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга С.Эрдэнэбат нээж үг хэллээ. Тэмцээнд нийт 6 цэцэрлэгийн 250-н бяцхан тамирчид оролцлоо. Шүүгчдийн бүрэлдэхүүнд Нийслэлийн Биеийн тамир, спорт хорооны Биеийн тамирын хэлтсийн дарга олон улсын хэмжээний мастер А.Болдмаа, гимнастикийн улсын шүүгч А.Болорцэцэг, гимнастикийн Олон улсын хэмжээний мастер улсын шүүгч Ц.Март нар шүүн явууллаа. Шагналт байранд:

1-р байр С.Уранчимэг эрхлэгчтэй 59-р цэцэрлэг
2-р байр Ч.Наранцацрал эрхлэгчтэй 129-р цэцэрлэг
3-р байр Б.Даваасамбуу эрхлэгчтэй 62-р цэцэрлэг
Тусгай байр Л.Ууганбаяр эрхлэгчтэй 52-р цэцэрлэг тус тус эзэллээ.





БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН ӨСВӨРИЙН “СПОРТ ЯВГАН АЯЛАЛ”-ЫН АРГА ХЭМЖЭЭ

Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын өсвөрийн “Спорт явган аялал”-ын арга хэмжээг 2022 оны 05 дугаар сарын 13-14-ны өдөрүүдэд Жуковын талбайгаас – Хар усан тохой чиглэлд 18 км замыг туулан амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээнд нийт 4 сургуулийн 10 багийн 80 тамирчин



- Уулын оргил булаалдах
- Хөгжилтэй буухиа тэмцээн
- Нуувч олох
- Багийн ахлагч
- Газрын зураг ажиллах 5 төрлөөр өрсөлдлөө.



Арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд Баянзүрх дүүргийн Спортын хорооны дарга Д.Отгонсүрэн баг тамирчдад амжилт хүсч баяр хүргэлээ.

Тэмцээний шагналт байранд :

- 1-р байр 88-р сургууль “Чоно” баг
- 2-р байр 44-р сургууль “Сүлд1” баг
- 3-р байр 69-р сургууль “Од” баг тус тус шалгарлаа.

Эрэгтэй шилдэг тамирчнаар

- 88-р сургууль “Чоно” баг Т.Отгондэлгэр

Эмэгтэй шилдэг тамирчинаар

- 69-р сургууль “Барс” баг Ж.Амгаланзаяа
- Шилдэг дасгалжуулагчаар 69-р сургууль Э.Цогзолмаа нар тус тус шалгарлаа.





БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН НАСНЫ ХҮҮХДИЙН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН "ЗУУН БУУДАЛТ ДААМ"-НЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хороо, Боловсролын хэлтэс, 147-р цэцэрлэгтэй хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулагдаг цэцэрлэгийн 5-6 насны хүүхдүүдийн дунд "Зуун буудалт даам"-ны аварга шалгаруулах тэмцээнийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр 147-р цэцэрлэгт амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд нийт 25 цэцэрлэгийн 80 тамирчид 2 насны ангилалд оролцлоо.



Тэмцээний нээлтийн үйл ажиллагаанд Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хорооны дарга Д.Отгонсүрэн баг тамирчдад амжилт хүсч баяр хүргэлээ.



Насны ангилал тус бүрт нь байр эзлүүлж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнав.
Шагналт байранд:



6 насны эрэгтэй.

- 1-р байр А.Ерболат 115 цэцэрлэг
- 2-р байр Т.Түвшинтөр Мөнхтүшиг цэцэрлэг
- 3-р байр Д.Түвшинтөр 301 цэцэрлэг

6 насны эмэгтэй.

- 1-р байр А.Маргад 289 цэцэрлэг
- 2-р байр Б.Алтанзул 115 цэцэрлэг
- 3-р байр Б.Отгондаваа 301 цэцэрлэг



5 насны эрэгтэй.

- 1-р байр Б.Маргад 146 цэцэрлэг
- 2-р байр Э.Содмөнх 147 цэцэрлэг
- 3-р байр Г.Хүдэрхангай 32 цэцэрлэг

5 насны эмэгтэй.

- 1-р байр Э.Оюунтүлхүүр Хөөрхөн маамуу цэцэрлэг
- 2-р байр М.Нарангуа 301 цэцэрлэг
- 3-р байр Б.Танхил 146 цэцэрлэг



Багийн нийлбэр дүнгээр

- 1-р байр О.Оюунмаа эрхлэгчтэй 301-р цэцэрлэг
- 2-р байр С.Ариунбаяр эрхлэгчтэй 146-р цэцэрлэг
- 3-р байр Х.Чимэдцэрэн эрхлэгчтэй 147-р цэцэрлэг шалгарч шагналт байранд орсон баг тамирчдыг өргөмжлөл мөнгөн шагналаар шагнав.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН “ХОНХОТ БӨМБӨГ”-ИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭН

Дүүргийн хүн амын эрүүл мэндийг бэхжүүлж, хамгаалах, нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээнд өргөнөөр хамруулах ажлын хүрээнд хараагүй иргэдийн дунд хонхот бөмбөгийн тэмцээнийг жил бүр уламжлал болгон зохион явуулж, тэднийг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, сэтгэл санаа бие бялдрыг сэргээн баг тамирчдын ур чадвар туршлагыг нэмэгдүүлэх зорилгоор Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо, Монголын хонхот бөмбөгийн холбоо хамтран 2022 оны 03 дугаар сарын 19-нд Хараагүйчүүдийн Үндэсний холбооны биеийн тамирын зааланд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд эрэгтэй 4 баг, эмэгтэй 4 баг нийт 8 багийн 48 тамирчин оролцож дүнгээ гаргалаа. Тэмцээний шагналт байранд:



ЭРЭГТЭЙ

1-р байр Г.Батдэлгэр ахлагчтай БГД
 2-р байр У.Чанцалтогтох ахлагчтай ХУД
 3-р байр Н.Цэрэнтогтох ахлагчтай СБД
 тус шалгарлаа.




ЭМЭГТЭЙ

1-р байр Ө.Нандин-Эрдэнэ ахлагчтай ХУД
 2-р байр С.Туяацэцэг ахлагчтай БГД
 3-р байр С.Анарцэцэг ахлагчтай СБД тус



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН " ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ МОНГОЛ" АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ЦАХИМ СУРГАЛТ

Баянзүрх дүүргийн харьяа хэлтэс алба, цэцэрлэг, хороодын спорт хамтлагийн арга зүйч, биеийн тамирын багш нарын дунд "ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ - ЭРТЭЧ МОНГОЛ" аяны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх цахим сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 21 -ны өдөр явууллаа. Сургалтад нийт 48 байгууллагын 50 хамтлагийн арга зүйч багш нар хамрагдаж аяны талаар мэдээлэл, сургалтыг авлаа.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН " ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ МОНГОЛ" АЯНЫ ХҮРЭЭНД БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД ЯВАГДСАН АЖЛУУД

Биеийн тамир, спорт хорооноос БЗД-ын 22-р хороонд орших "Их цайз" спорт заалтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажлын 5 өдрийн өглөө 06.30-07.30 цагийн хооронд иргэдэд дасгал хөдөлгөөн хийх нөхцөл боломжоор ханган зохион байгуулж ажиллалаа. Мөн Баянзүрх дүүргийн иргэдийн хүсэлтээр алслагдсан газар дасгал хөдөлгөөн хийх саналыг үндэслэн 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс 05 дугаар сарын 30-ныг хүртэл Баянзүрх дүүргийн 12 хороо Жанжин клубын урд заалыг тус тус түрээслэн нийт **3,520** иргэдэд үйлчилгээ үзүүллээ.

Аяны нийт хугацаанд Баянзүрх дүүргийн иргэдийн дунд "Чөлөөт дасгал хөдөлгөөн, шатар, даам, ширээний теннис"-ний төрлөөр чөлөөт тоглолт хийх арга хэмжээг 16-р хороо 72 хотхоны автобусны буудал БОСА худалдааны төвийн эсрэг талд байрлах "НӨХӨРЛӨЛ-ШАТАР, ДААМ, ШИРЭЭНИЙ ТЕННИС" клубд зохион байгуулж үнэ төлбөргүйгээр уг арга



хэмжээг ажлын өдрүүдэд 15-18 цагт, ням гарагт 15-19 цагт зохион байгуулан нийт **2,880** иргэн хамрагдлаа.

Мөн цэцэрлэг, сургууль, албан байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгч өөрийн нөхцөл бололцоогоо ашиглан оролцохыг зөвлөгөө өгсөн ба энэ нь үр дүнгээ өгч цэцэрлэг, сургуулиуд энэхүү аянд нэгдэн өглөө, өдрийн ээлжээр дасгалаа хийн **БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ ЭРТЭЧ МОНГОЛ 2022** FB группд багш, ажилтан албан хаагч нараа дасгал хөдөлгөөнд хамруулсан бичлэг, зургийг оруулан тогтмол мэдээллээд байна.



2022-03-21
"ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ- ЭРТЭЧ МОНГОЛ" АЯНЫ ХҮРЭЭНД БЭД-ИЙН ТЭРГҮҮНИЙ 62-ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ХАМТ ОЛОН ШИНЭ ДАСГАЛДАА АЖЛЫН БАЙРАН ДЭЭР 12 ХҮН ГЭРЭЭР 2 ХҮН НИЙТ 14 ХҮН ОРОЛЦЛОО.



“ЭРҮҮЛ ХООЛЛОЛТ-ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨН -ЭРҮҮЛ БИЕ” СЭДЭВТ СУРГАЛТ

Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооноос “ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ МОНГОЛ” аяны хүрээнд Баянзүрх дүүргийн хороодын Биеийн тамир, спортын хамтлагийн ахлагч болон ажилтан, албан хаагч нарын дунд “ЭРҮҮЛ ХООЛЛОЛТ-ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨН-ЭРҮҮЛ БИЕ” сэдэвт сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр дүүргийн тамгын газрын хурлын танхимд зохион байгууллаа. Сургалтад **31** хорооны **43** хамтлагийн ахлагч болон ажилтан, албан хаагчид хамрагдлаа. Сургалтыг

- “Халдварт бус өвчин ба эрүүл амьдралын хэв маяг” эрүүл мэндийн төвийн халдварт бус өвчин хариуцсан мэргэжилтэн Д.Энхцэцэг
- “Эрүүл зөв хооллолт” эрүүл мэндийн төвийн хоол зүйч А.Наранжаргал
- “Ковидын дараах сэтгэл зүй” эрүүл мэндийн төвийн сэтгэл зүйч магистр Ө.Оюунбилэг
- “Дасгал хөдөлгөөн ба эрүүл мэнд” нийгмийн эрүүл мэндийн төвийн ЭМДӨУСА-ны эрдэм шинжилгээний ажилтан БСУ-ны магистр Х.Бямбасүрэн
- “Эрүүл мэндийн дасгал” эрүүл мэндийн төвийн арга зүйч Б.Сансартуяа
- “Иргэдийн спортын наадам хороонд зохион байгуулах тухай” спортын бодлого хариуцсан мэргэжилтэн Г.Ууганжаргал
- “Биеийн тамир, спортын хорооноос жил бүр зохион байгуулдаг хороод болон иргэд рүү чиглэсэн уралдаан тэмцээний тухай” Биеийн тамирын мэргэжилтэн Э.Уянга нар зохион байгууллаа.





БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН “ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ МОНГОЛ” АЯНЫ ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЭРОБИК, ХИЙН ДАСГАЛЫН СУРГАЛТ

Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооноос “ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ - ЭРТЭЧ МОНГОЛ” аяны хүрээнд аэробик, хийн дасгалын сургагч багш бэлтгэх сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 11-нээс 04 дүгээр сарын 15-ны өдөр “ЭХЛЭЛ” таеквандогийн клубд зохион байгуулагдаж өндөрлөлөө. Сургалтад **25** хорооны **43** хамтлагийн ахлагч, болон хороодын нийгмийн ажилчид хамрагдлаа. Сургагч багшийн сургалтыг:

“Бие чийрэгжүүлэх 8 дасгал”: Монголын хийн дасгалын холбооны тэргүүн, хийн дасгалын холбооны уламжлагч багш доктор профессор Х.Оюунбилэг

“Золбоот хэмнэл аэробик”: гимнастикийн спортын мастер А.Болорцэцэг, А.Ариунаа

“Бие бялдрын түвшин тогтоох сорил авах аргачлал”: Баянзүрх дүүргийн биеийн тамирын хэлтсийн дарга С.Сувд, эрүүл мэндийн төвийн арга зүйч Б.Сансартуяа нар сургалтыг удирдан явууллаа.



“БАЯНЗҮРХ КАП-2022” 3x3 САГСАН БӨМБӨГИЙН СОНИРХОГЧДЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ФЕСТИВАЛЬ

Баянзүрх дүүргийн хэмжээнд хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэднийг спортоор дамжуулан эрүүл өв тэгш бие бялдртай иргэнийг бий болгох зорилгоор 2022 онд 15-н хороонд, 2024 онд 30-н хороонд 3x3 сагсан бөмбөгийн талбай байгуулах юм. Үүнээс 2022 онд Баянзүрх дүүргийн 9, 24, 28, 34, 42-р хороонд олон улсын стандартад нийцсэн 3x3 сагсан бөмбөгийн таван талбай ашиглалтад орлоо.

Баянзүрх дүүрэгт олон улсын стандартад нийцсэн 3x3 сагсан бөмбөгийн талбайн нээлтийн арга хэмжээг тохиолдуулан “Баянзүрх CUP-2022” 3x3 сагсан бөмбөг сонирхогчдын аварга шалгаруулах фестивалийг Баянзүрх дүүргийн 9, 24, 28, 34, 42-р хороонд байрлах 3x3 сагсан бөмбөгийн талбайд 2022 оны 07-р сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгууллаа.



УИХ-ын гишүүн Э.Бат-Амгалангийн санаачилсан “Баянзүрх-CUP” 3x3 сагсан бөмбөг сонирхогчдын аварга шалгаруулах тэмцээний ерөнхий зохион байгуулагчаар Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо,

- Баянзүрх дүүргийн 9, 24, 28, 34, 42-р хороо
- Баянзүрх дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс
- Баянзүрх дүүргийн Хууль зүйн хэлтэс
- Баянзүрх дүүргийн Төрийн захиргаа удирдлагын хэлтэс
- Баянзүрх дүүргийн Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс
- Баянзүрх дүүргийн Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс
- Баянзүрх дүүргийн Тохжилт нийтийн аж ахуйн хэлтэс
- Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв
- Баянзүрх дүүргийн Соёлын ордон хамтран зохион байгууллаа.

Баянзүрх дүүргийн 9-р хороонд тэмцээний нээлтийн арга хэмжээ болж, УИХ-ын гишүүн Э.Бат-Амгалан, Баянзүрх дүүргийн Засаг дарга Н.Баярмөнх, Засаг даргын орлогч Г.Жаргалсайхан, Тамгын газрын дарга И.Баттөгс Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Мөнгөншагай, Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Г.Шүрэнцэцэг болон бусад албаны хүмүүс оролцлоо.



Баянзүрх дүүргийн 9-р хороонд бидний гудамж төслийг хэрэгжүүлж, ахмадууд амрах, хүүхдүүд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжтой орчныг бий болголоо. Тэмцээнд 60 багийн 300 гаруй тамирчин, дасгалжуулагч албаны 100 гаруй хүмүүс оролцлоо. Энэхүү тэмцээний хоёр дахь өдөр 4-н бүсээс шалгарсан шилдэг 16-н багууд Баянзүрх дүүргийн 9-р хороонд байрлах Шархадны шинээр ашиглалтад орсон бидний гудамжинд ялагчдаа тодрууллаа.

Баянзүрх Кап 2022” 3x3 сонирхогчдын аварга шалгаруулах тэмцээнд дараах багууд шилдгээр шалгарлаа. Үүнд:

- Тэргүүн байранд УИХ-ын гишүүн Э.Бат-Амгалангийн удирдан дасгалжуулсан Э.Магсаржав ахлагчтай “RHINO” баг



- Хоёрдугаар байранд Баянзүрх дүүргийн ИТХ-ын төлөөлөгч Д.Өлзийдэмбэрэлийн удирдан дасгалжуулсан В.Орхон ахлагчтай “SKY” баг



- Гуравдугаар байранд Баянзүрх дүүргийн ИТХ-ын төлөөлөгч Ц.Ууганбаярын удирдан дасгалжуулсан С.Тэмүүжин ахлагчтай “Ахан дүүс” баг тус тус шалгарлаа.
- Тэмцээний шилдгийн шилдэг тоглогч MVP шагналыг УИХ-ын гишүүн Э.Бат-Амгалангийн удирдан дасгалжуулсан Э.Магсаржав ахлагчтай “RHINO” багийн тамирчин С.Мөнх-Алдар хүртлээ.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ СПОРТЫН ХОЁР ТӨРӨЛТ АРГА ХЭМЖЭЭ

Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хороо, Баянзүрх дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс хамтран залуучуудын өдрөөр Баянзүрх дүүргийн хороодын иргэдийн дундах 2 төрөлт арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.

Арга хэмжээний 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнийг 2022 оны 08 дугаар сарын 25-наас 26-ны хооронд Баянзүрх дүүргийн 34 дүгээр хорооны 3х3 сагсан бөмбөгийн талбайд, дартсын тэмцээнийг 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр Монголын дартс сонирхогчдын холбооны MGL-ын байранд зохион байгууллаа. Арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 22 багийн 110-н тамирчин, дасгалжуулагч албаны 20 хүн оролцлоо.

3х3 сагсан бөмбөгийн төрөлд:

Нэгдүгээр байр Г.Мягмардорж Засаг даргатай 9-р хороо
 Хоёрдугаар байр Н.Батсүх Засаг даргатай 24-р хороо
 Гуравдугаар байр Б.Хасбаатар Засаг даргатай 2-р хороо





Дартсын төрөлд:
 Нэгдүгээр байр Ч.Оюунцэцэг Засаг даргатай 30-р хороо
 Хоёрдугаар байр З.Цэрэнмаа Засаг даргатай 17-р хороо
 Гуравдугаар байр Л.Пүрэвдулам Засаг даргатай 38-р хороо



Багийн нийлбэр дүнгээр:
 Нэгдүгээр байр З.Цэрэнмаа Засаг даргатай 17-р хороо
 Хоёрдугаар байр Н.Эрдэнэзаяа Засаг даргатай 21-р хороо
 Гуравдугаар байр Х.Батзаяа Засаг даргатай 12-р хороо тус тус шалгарлаа.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН Х НААДМЫН “СПОРТ ЯВГАН АЯЛАЛ”-ЫН ТЭМЦЭЭН

Баянзүрх дүүргийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн А/595 дугаар захирамжийн дагуу Баянзүрх дүүргийн “Иргэдийн спортын Х наадам”-ын “Спорт, явган аяллын тэмцээнийг 2022 оны 09 дүгээр сарын 03-04-ны хооронд Жуков-Хар усан тохой чиглэлд 10, 12, 15, 17, 20, 21, 22, 30, 31, 32, 33, 36, 37, 39, 41, 43-р хорооны 16 багийн 176 тамирчин, дасгалжуулагч албаны 25 хүн оролцлоо.

Спорт явган аяллын тэмцээнийг

1. Газрын зураг дээр ажиллах
2. Нуувч илрүүлэх
3. Хөгжилтэй буухиа
4. Галын болон отгын ариун цэвэр
5. Техник үзлэг
6. Аялах явц, зохион байгуулалт зэрэг үзүүлэлтээр дүгнэлээ.

Нийлбэр оноогоор эхний байруудыг дараах хороод эзэллээ.

1. Н.Тулга Засаг даргатай 41-р хороо (Даян арвижих) баг



3. Цэрэнмаа Засаг даргатай 17-р хороо (Баянзүрх 17) баг
- Х.Батжаргал Засаг даргатай 22-р хороо (Дэвжих) баг тамирчид авхаалж самбаа, хурд хүчээ дайчлан амжилттай оролцлоо.



“МОНГОЛЫН ТАМИРЧДЫН БАЯР”-ЫН ӨДРИЙН ХҮРЭЭНД БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНООС ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолоор “Монголын тамирчдын өдөр”-ийг жил бүрийн зургаадугаар сарын сүүлчийн долоо хоногийн ням гарагт зохион байгуулдаг бөгөөд 86 дах жилдээ тэмдэглэн өнгөрүүлж байна.



Энэхүү баярын арга хэмжээнд Спортын төв ордны урд талбайгаас Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөх хүндэтгэлийн ёслолын үйл ажиллагаа баярын парадаар алхан, спортын үзүүлэх тоглолт явагдлаа. Энэхүү үйл ажиллагаанд Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Д.Жаргалсайхан, Бодлого төлөвлөлтийн газрын дарга О.Гэрэл, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга О.Баттулга, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга Ж.Ганболд болон дүүргүүдийн Биеийн тамир, спортын хорооны дарга нарын хүндтэй эрхмүүд оролцлоо. “Монголын тамирчдын өдөр”-ийн арга хэмжээнд Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо, Баянзүрх дүүргийн “Алдар спортын хороо, Ахмад мастеруудын холбоо, Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх гимнастик, самбо, жүдо бөхийн өсвөрийн шигшээ багийн хүүхдүүд нийт 5 байгууллагын 100 тамирчдын бүрэлдэхүүнтэй оролцлоо. Үүнээс 30 хүүхдүүд, 40 залуучууд, 30 ахмадууд байлаа. “Монголын тамирчдын баярын үзүүлэх тоглолтын үеэр Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх гимнастикийн өсвөрийн шигшээ багийн тамирчид үзүүлбэр үзүүллээ.



“Монголын тамирчдын өдөр”-ийн 86 дахь жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд спорт хорооны дарга, мэргэжилтэн, ажилтан, албан хаагчид нийт 14-н хүнийг “АЛДАРШУУЛЪЯ” аяны хүрээнд 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс 7 хоногийн хугацаанд Спорт хороо Баянзүрх facebook болон bzd.sport.gov.mn сайт хаягаараа дамжуулан мэдээлэл хүргэж ажиллав.

Баянзүрх Дүүргийн Биеийн тамир спортын хороо



ГҮРСЭДИЙН ЭНХБАЯР

Өсвөрийн шигшээ багч, хүүхдийн спортын асуудал хариуцсан мэргэжилтэн
Ажилласан жил: 35
Мэргэжил: Биеийн тамирын багш, дасгалжуулагч
Гавьяа шагнал:
- Монгол Улсын Гавьяат дасгалжуулагч
- Төрийн дээд шагнал “Алтан гадас” одон
- Олон Улсын хэмжээний мастер
- Биеийн тамир спортын “Тэргүүний ажилтан”
- “Боловсролын тэргүүний ажилтан”
- “Олимпын алдар” одон
- “Алтан очир” одон
- Монголын үндэсний олимпын хорооны тэргүүн дээд шагнал “Алтан од” одон
- Монгол Улсын болон Нийслэлийн “Шилдэг дасгалжуулагч”

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО



ЮНГЭРЭНДОРЖИЙН БАТСАЙХАН

Спортын хэлтсийн дарга
Ажилласан жил: 23
Мэргэжил: Чөлөөт бөхийн дасгалжуулагч, багш
IWW-н Олон улсын шүүгч
Гавьяа шагнал:
- Төрийн дээд шагнал “Алтан гадас” одон
- Биеийн тамир, спортын тэргүүний ажилтан
- МҮОХ-ны “Алтан медаль”
- МҮОХ-ны “Олимпын алдар” одон
- МҮОХ-ны “Алтан очир” одон
- БТСУХ- “Спортын алдар” медаль
- Баянзүрх дүүргийн хөдөлмөрийн аварга

“Тамирчдын өдөр”-ийн арга хэмжээнд 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлангаа РРТ-ээр бэлтгэн иргэд болон тамирчдад танилцуулан, 10 төрлийн 250 ш гарын авлага, зөвлөмж бэлтгэн тамирчдад тараан сурталчилж, Нийслэлийн Биеийн тамир, спорт хороотой хамтран Биеийн тамир, спортын тулгамдсан асуудлын талаар тамирчид болон иргэдээс санал асуулгын хуудсыг авч ажиллав.



Баянзүрх дүүргийн Биеийн тамир спорт хорооны дэргэдэх ахмад мастеруудын холбоо 2022 оны 06 дугаар сарын 24-25 -ны өдөр зохион байгуулагдсан “Гранд гольф”-ийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцон тэргүүн байр эзлэн “Монголын тамирчдын баярын өдөр”-ийн арга хэмжээн дээр Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Д. Жаргалсайханаас тэргүүн байрын шагналаа гардан авлаа.





БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН Х НААДМЫН "ОЛС ТАТАЛТ"-ЫН ТЭМЦЭЭН

Баянзүрх дүүргийн Иргэдийн спортын Х наадмын "Олс таталт"-ын тэмцээн 2022 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр 30-р сургуулийн гадна талбайд амжилттай зохион байгуулагдаж дүнгээ гаргалаа. Нийт 22 хорооны эмэгтэй 19 баг, эрэгтэй 22 багийн 369 иргэн хамрагдаж багийн дүнгээр:

Эмэгтэй: 1-р байр 32-р хороо
2-р байр 27-р хороо
3-р байр 41-р хороо
Эрэгтэй: 1-р байр 27-р хороо
2-р байр 20-р хороо
3-р байр 24-р хороо тус тус шалгарлаа.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ДУНДАХ "БАЯНЗҮРХ КАП 3x3" САГСАН БӨМБӨГ

Баянзүрх дүүргийн ЕБС-иудын дундах "Баянзүрх кап 3x3" Сагсан бөмбөгийн тэмцээн 2022 оны 09 дүгээр сарын 17-наас 18-ны өдрүүдэд 28, 42 дугаар хорооны 3x3 сагсан бөмбөгийн талбайд эрэгтэй 26 баг, эмэгтэй 15-н багийн 200 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Шагналт байранд шалгарсан багууд:

Эрэгтэй төрөлд:

- 1-р байранд М.Уянга дасгалжуулагчтай 21-р сургууль
- 2-р байранд Н.Шижирбат дасгалжуулагчтай 33-р сургууль
- 3-р байранд Б.Ганбаяр дасгалжуулагчтай 92-р сургууль

Эмэгтэй төрөлд:

- 1-р байранд П.Жавзанпагма дасгалжуулагчтай 84-р сургууль
- 2-р байранд Б.Ууганхүү дасгалжуулагчтай 79-р сургууль
- 3-р байранд Билгүүн дасгалжуулагчтай 48-р сургууль тус тус эзэллээ.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ХОРООНООС АВТОМАШИНГҮЙ ӨДРИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН “СПОРТЛОГ УЛААНБААТАР 2022” АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/1206 дугаар захирамж “Автомашингүй өдөр” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Спортлог Улаанбаатар 2022” арга хэмжээг Сүхбаатарын талбайд амжилттай зохион байгуулагдлаа.

Нээлтийн үйл ажиллагаанд Улаанбаатар хотын сайд Ж.Сүхбаатар, Олимп нийтийн биеийн тамир, спортын сайд Б.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөө нар оролцсон бөгөөд 9 дүүргийн биеийн тамир, спорт хороодоор явж үйл ажиллагаатай танилцсан юм.

Өдөрлөгийн үеэр

- БЗД-ийн Засаг даргын дэргэдэх олон улсын шүүгч Э.Оргилмаа дасгалжуулагчтай Спортын гимнастикийн өсвөрийн шигшээ баг үзүүлэх тоглолт хийлээ.
- Ахмадын Төгөлдөр дасгалыг нийтээрээ хийж гүйцэтгэлээ.
- Зөв амьдрах дадал хэв маягт сургах, дасгал хөдөлгөөнийг зөв зохистой хийж хэвших, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар 10 төрлийн 800 гаруй гарын авлага, боршюр хэвлэн тараасан.
- Өдөрлөгийн үеэр биеийн тамир, спортын хорооноос нээлттэй дартс, дээсэнд үсрэх 2 төрлийн тэмцээнийг зохион байгуулж 100 гаруй иргэдийг хамрууллаа. Тэмцээний эхний гурван байранд шалгарсан иргэдийг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.





Дээсэнд үсрэлтийн төрөлд:

Эрэгтэй

- 1-р байр: Ч. Бадрах
- 2-р байр В.Батжаргал
- 3-р байр Т.Мөнхтулга

Эмэгтэй

- 1-р байр: Д. Баяржаргал
- 2-р байр З.Ганчимэг
- 3-р байр Н.Одгэрэл

Дартсын төрөлд:

Эрэгтэй

- 1-р байр: Л. Өнөржаргал
- 2-р байр Л. Пүрэвсүрэн
- 3-р байр Ө.Буянтогтох

Эмэгтэй

- 1-р байр: Д.Оюунтуяа
- 2-р байр Б.Ганчимэг
- 3-р байр Ж. Саранчимэг тус тус шалгарлаа.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ӨСВӨРИЙН ШАТАРЧДЫН “ИХ НҮҮДЭЛ” УЛАМЖЛАЛТ ТЭМЦЭЭН

Хүүхэд багачуудыг шатрын спортоор хичээллүүлэн оюуны чадамжийг дээшлүүлэх, тоглох ур чадварыг нээн илрүүлэх, улс эх орон, гадаад дотоодын тэмцээнүүдэд тогтмол амжилттай оролцуулан алдаршуулах, ирээдүйн их мастеруудыг төрүүлэн гаргах зорилгоор Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулдаг “Их нүүдэл” шатрын дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтэс, Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо хамтран 2022 оны 10 дугаар сарын 21-ны өдөр 147 дугаар сургуулийн урлаг заал болон ангиудад хуваарилагдан "Швейцарийн систем"-ээр 6 өрөг тоглож аваргуудаа тодрууллаа. Тэмцээнд 14, 33, 30, 120, 133, 102, 53, 147, 69, 48, 148, 155, 85, 127, 88, 142, Амгалан ЦС, Гёте зэрэг 18-н сургуулийн 432 шатарчин сурагч оролцож тэмцээний шагналт байранд

- 1-р байр Н.Энхбат захиралтай 33 дугаар сургууль
- 2-р байр Н.Гунгаажав захиралтай 14 дүгээр сургууль
- 3-р байр П.Өлзийтөгс захиралтай 30 дугаар сургууль тус тус шалгарлаа.





БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН “АХМАДЫН СПОРТЫН АНХДУГААР ИХ НААДАМ”

Баянзүрх дүүргийн 43-н хороодын ахмадуудын дунд Ахмадын спортын анхдугаар их наадмыг 2022 оны 10 дугаар сарын 10-30-ны хооронд спортын 6 төрлөөр анх удаа зохион байгуулж өндөрлөлөө. Энэхүү тэмцээнийг цаашид үргэлжлүүлэн 2 жилд 1 удаа зохион байгуулна.

Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо, Баянзүрх дүүргийн Ахмадын хороотой хамтран “Ахмадын спортын анхдугаар их наадам”-ыг дараах төрлүүдээр зохион байгууллаа.

1. Баянзүрх дүүргийн ахмадын “СОФТ ВОЛЕЙБОЛ”-ын аварга шалгаруулах тэмцээнийг 2022 оны 10 дугаар сарын 12-наас 13-ны өдөр Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн зааланд зохион байгуулагдлаа. Тэмцээнд 21-н хорооны 21 багийн 147 ахмад тамирчид оролцлоо.

1-р байр Л.Дашдорж ахлагчтай 26, 36-р хороо

2-р байр С.Сүхээ ахлагчтай 16-р хороо

3-р байр Б.Алтанцэцэг ахлагчтай 6-р хороо



2. Баянзүрх дүүргийн ахмадын “ГРАНД ГОЛЬФ”-ийн аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Баянзүрх дүүргийн 4-р хороонд байрлах 15-ын хөл бөмбөгийн талбайд зохион байгуулагдлаа. Тэмцээнд 21-н хорооны 21 багийн 40 тамирчин “Алтан бөмбөг”-ний эзэн болсон бол 150 гаруй ахмад тамирчид оролцлоо.

Эмэгтэй насны ангилал

55-64 нас

1-р байр Н.Цэцэгмаа 36-р хороо

2-р байр н.Дариймаа 26-р хороо

3-р байр н.Ганчимэг 22-р хороо

+65 нас

1-р байр Ж.Сугар 17-р хороо

2-р байр Б.Отгон-Уул 22-р хороо

3-р байр н.Гаамаа 17-р хороо

Эрэгтэй насны ангилал

60-64 нас

1-р байр П.Энхбаатар 3-р хороо

<p>зорилгоор “Алхацгаая гүйцгээ” хөдөлгөөнийг өрнүүлж 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сар хүртэл тогтмол зохион байгуулж, иргэдийг идэвхтэй хамруулах.</p>	<p>дүгээр сар хүртэл тогтмол зохион байгуулна. Энэ хүрээнд дүүргийн Засаг даргын захирамж гарган, зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг батлуулж, Баянзүрх дүүргийн 28 хороодтой хамтран ажиллах юм.</p> <ul style="list-style-type: none"> - Дүүргийн иргэдийн дунд “Алхацгаая гүйцгээ” хөдөлгөөний хүрээнд алхалтыг сар бүрийн 2, 4 дэх 7 хоногийн бямба гарагт тогтмол зохион байгууллаа. - Дүүргийн Засаг даргын захирамжийн төслийг Нийгмийн хөгжлийн хэлтэс рүү явуулж батлуулахаар ажиллаж байна. - 28 Хороодруу явах албан бичгийг төлөвлөн бэлдээд байна. <p>Мөн “Алхацгаая гүйцгээ” хөдөлгөөний нээлтийн үйл ажиллагааг 4 дүгээр сарын 09-ний өдөр үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгууллаа.</p>
---	---

1.7.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн

ЗГТА Биеийн тамир спортын Улсын хорооны даргын 2020 оны 12 сарын 18-ны өдрийн А/98 тушаал гарч 2-р хавсралтын дагуу Биеийн тамир спортын цахим сан хөгжүүлэлтийг амжилттай явуулж байна.

Байгууллагын <https://cpanel.sport.gov.mn/> сайтаар тэмцээн наадам цэст Монголын Үндэсний Спортын VII Наадмын цахим бүртгэлийг өвлийн спортын 2 төрөл, зуны спортын 9 төрөл, үзүүлэх тоглолтын 4 төрлийг зуны спортын төрлөөр давхардсан тоогоор 141 хүний бүртгэлийг хийж Монголын Бүх Ард Түмний XV Наадмын цахим бүртгэлийг Спортын 17 төрөлд 371 тамирчин бүртгэж анхан шатны тэмцээнээс шалгарсан 201 тамирчинг системд баталгаажууллаа. Тэмцээн уралдааны тайлан мэдээг байгууллагын bzd.sport.gov.mn сайтад байршуулсан. Улаанбаатар марафон 2022 олон улсын гүйлтэд <http://ubmarathon.hipay.mn/> сайтаар 1,684 иргэдийн бүртгэлийг хийж 5 км гүйлтэд оролцох эрхийг баталгаажууллаа. Байгууллагаас зохион байгуулж байгаа болон олон нийтийн ажилд оролцож Биеийн тамирын хэлтэс, Спортын хэлтэст зохион байгуулсан арга хэмжээнд тухай бүр оролцож мэдээллийг байгууллагын сайт болон <https://www.facebook.com/search/top/> фэйсбүүк хуудаст орууллаа. Байгууллагын сайт нь Нүүр хуудас, Спортын хороо, Хууль эрх зүй, Цаг үеийн мэдээ (Онцлох мэдээ, тэмцээний заавар, удирдамж, фото мэдээ, видео, зөвлөгөө, нийтлэл), Ил тод байдал (Шилэн данс, үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдал, хөрөнгө оруулалт, төсөв, санхүү, тендер, анкет, маягт, өргөдөл, гомдол, цол зэрэг), Өсвөрийн шигшээ баг (дасгалжуулагчид, тамирчид, тайлан), Холбоо барих (фб хуудас, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, байршил), МБАТС-ын XV наадам гэсэн цэснүүдээс бүрдэж байгаа бөгөөд 2022 онд 220 мэдээ мэдээллийг нийтэлж 13,000 гаран хандалт авсан байна.





1.8.Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн

- 2022 оныг Баянзүрх дүүргээс “**Бүтээн байгуулалтын жил**” болгон зарлалаа. Бүтээн байгуулалтын жилд Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо Нийтийн их цэвэрлэгээг 6 удаа зохион байгуулж, Бүх нийтийн мод тарих өдөрт 2 удаа оролцож мод тарилаа.
- “**ХОГГҮЙ ОРЧИН**” нийтийн их цэвэрлэгээ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62.1 дүгээр зүйлийн 62.1.1, 62.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Баянзүрх дүүргийн Засаг даргын А/40 дугаар захирамжийг тус тус үндэслэн 2022 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр “Хоггүй орчин” их цэвэрлэгээг зохион байгуулж Шархадны эмнэлэгийн урд талбай дээр нээлтийн үйл ажиллагаанд Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спорт хорооны ажилтан, албан хаагчид 7 хүний бүрэлдэхүүнтэй оролцож хуваарийн дагуу Цайз захын уулзвараас – Эрдэнэ-Толгойн автобусны буудал хүртэлх замын 2 талын газарт их цэвэрлэгээ хийлээ.



- “**ХОГГҮЙ ОРЧИН ХАВАР**” бүх нийтийн их цэвэрлэгээ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 32/03 дугаар тогтоолоор батлагдсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилал, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.3 дахь заалт, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/08 дугаар тушаалыг тус тус үндэслэн Баянзүрх дүүргийн “ХОГГҮЙ-ОРЧИН-ХАВАР” аяныг 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулагдлаа. Тус аянд Баянзүрх дүүргийн биеийн тамир спорт хорооны ажилтан, албан хаагчид Сансарын колонкоос Е-мартын уулзвар хүртэл 3,465 м² талбайд цэвэрлэгээ хийж, хог хаягдлыг хогийн машинд ачууллаа. Нийт 36 шуудай хог хаягдал гарсан байна.



- “**БҮХ НИЙТИЙН МОД ТАРИХ ӨДӨР**”-ийн хүрээнд мод тарилаа

Монгол Улсын Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 63 дугаар зарлиг, 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигийн дагуу дүүргийн хэмжээнд “Мод тарих үндэсний өдөр”-ийг 2022 оны 05 дугаар сарын 06- 29-ний өдрүүдэд зохион байгуулах тухай дүүргийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/295 тоот захирамжийн хүрээнд мод тарих төлөвлөгөөний дагуу Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын



хорооны ажилтан, албан хаагчид 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Жанжин хүүхэд, залуучуудын цэцэрлэгт хүрээлэнд мод тарилаа.




- ГАДАА БҮХ НИЙТИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНД ОРОЛЦЛОО.

2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр 34-р хороо, Соёлын ордонтой хамтран Улиастайн голын баруун эргийг цэвэрлэлээ. Цэвэрлэгээнд 7 ажилтан оролцож 3 тн хог Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст хүлээлгэн өглөө.



- БҮХ НИЙТИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНД ОРОЛЦЛОО

Хог хаягдалгүй байлгахад анхаарч, 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Байгууллагын дотор цэвэрлэгээний ажлыг сайтар зохион байгуулж хамт олноороо идэвх санаачлагатай оролцлоо.



- “ХОГГҮЙ ОРЧИН” Бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгууллаа

Хог хаягдалгүй байлгахад анхаарч, их цэвэрлэгээний ажлыг сайтар зохион байгуулж хамт олноороо идэвх санаачлагатай оролцлоо.

2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр 41-р хорооны байр буюу Ангорын байрны гадна орчины 50метр талбайг цэвэрлэлээ. Цэвэрлэгээнд 7 ажилтан оролцож 2 тн хог Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст хүлээлгэн өглөө. Байгууллагын гадна болон дотор орчны цэвэрлэгээг хийлээ.





- “ХОГГҮЙ ОРЧИН” цас цэвэрлэгээг зохион байгууллаа

2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Байгууллагын орчин тойрны 50м газрын цас цэвэрлэгээнд гарч явган хүний зам талбайн цасыг цэвэрлэлээ.



2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Байгууллагын орчин тойрны 50м газрын цас цэвэрлэгээнд гарч явган хүний зам талбайн цасыг цэвэрлэлээ.



ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

2.1. Байгууллагын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилт, үр дүн

2022 оны “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г Дүүргийн засаг дарга болон ЗГТА-Биеийн тамир спортын улсын хорооны дарга нараар батлуулсан ба төлөвлөгөөнд тусгагдсан нийт 27 арга хэмжээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрээр ханган хэрэгжүүлэн ажиллалаа.

2.2. Нийслэлийн Засаг дарга болон дүүргийн Засаг даргын хооронд байгуулсан “Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх гэрээ”-ний хэрэгжилт, үр дүн

- ☐ Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас Баянзүрх дүүргийн засаг даргатай байгуулах хариуцлагын гэрээний биелэлтийг хавсралтаар орууллаа.
- ☐ Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

ГУРАВ.АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА - Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг

Зорилт 3.5. Биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.



3.5.1 Нийслэлийн хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээний чанар сайжирсан байна, 3.5.3 Нийслэлийн иргэдийн дунд биеийн тамир, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар оролцоог нэмэгдүүлсэн байна.

- Нийслэлийн Засаг Даргын 2022 А/546 дугаар захирамжийн дагуу “Улаанбаатар марафон” олон улсын гүйлт 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдөр 7 дахь удаагаа амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Улаанбаатар марафон олон улсын гүйлтэд Баянзүрх дүүргээс **1684** иргэд бүртгүүлэн оролцлоо. Баянзүрх дүүргийн хэмжээнд зохион байгуулсан “Улаанбаатар марафон-2022” олон улсын гүйлтийн арга хэмжээний хаалтын шагнал гардуулах ажиллагаа 2022 оны 05 дугаар сарын 28-нд Монгол Бөхийн Өргөөний урд талын талбайд боллоо. Шилжин явах цомын аяны хүрээнд дүүргийн хэмжээнд арга хэмжээ зохион байгуулж, идэвх санаачлагатай оролцсон дараах 4-н албан байгууллагуудыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

1. Байр -Татварын хэлтэс
2. Байр - 147-р цэцэрлэг
3. Байр - Дотоод хэргийн их сургууль
4. Байр - 44-р сургууль тус тус шалгарлаа.

-Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/177 дугаар захирамжийн хүрээнд иргэдэд зориулсан “Алхацгаая гүйцгээе” хөдөлгөөнийг 2022 оны 03 дугаар сарын 31-ээс 11 дүгээр сарын 05-ний өдрийг хүртэл төлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгууллаа. Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооноос “Алхацгаая-Гүйцгээе” хөдөлгөөний хүрээнд нийт **13** арга хэмжээг зохион байгуулж **293** байгууллагын **5,179** иргэн хамрагдсан байна. Нийт аяны хүрээнд давхардсан тоогоор **25,179** иргэн хамрууллаа.

- Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/497 дугаар захирамжийн хүрээнд “Иргэдийн спортын Их наадам” -ын биеийн тамирын арга хэмжээг Дүүргийн Засаг даргын 2022 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн А/595 дугаар захирамж гаргуулан дүүргийн хэмжээнд хэсэг, дүүрэг, нийслэл 3 үе шаттай 8 төрлөөр зохион байгууллаа.

Баянзүрх дүүргийн хэсгийн аварга шалгаруулах тэмцээнд 41 хорооны **10,282** иргэн хамрагдаж бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг 2022 оны 09 дүгээр сарын 24-өөс 10 дугаар сарын 02-ны өдрийн хооронд зохион байгуулж нийт **41** хорооны **242** багийн **2,324** тамирчид оролцож эхний 2 байранд шалгарсан баг тамирчид дүүргийн шигшээ тэмцээнд оролцох эрх авлаа.

Иргэдийн спортын Х наадмын дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг Хийн дасгал, аэробик 4 насны ангилалаар, Сагсан бөмбөг, Волейбол, Спорт явган аялал, Ширээний шагай наадгай, Олс таталтын төрлүүдээр 2022 оны 09 дүгээр сарын 2-ноос 11 дүгээр сарын 06-ны хооронд бүсээс шалгарсан **40** хорооны **111** багийн **1,150** тамирчин давхардсан тоогоор хамрагдаж тэргүүн байранд шалгарсан **14** багийн **155** тамирчин 2022 оны 11 дүгээр сарын 20-24 ны өдөр Нийслэлийн шигшээ тэмцээнд дүүргээ төлөөлөн 130 иргэн оролцлоо.

3.5.4 Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэдэг болсон байна.

-Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 07 дугаар сарын 06-нд батлагдан 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа ба тус шинэчилсэн найруулгын дагуу дүүргийн Засаг даргын 2018 оны 02 сарын 05-ны өдрийн А/33 тоот захирамжаар Өсвөрийн шигшээ багийн тоог 12-т хүргэн шинэчлэн байгуулж үйл ажиллагааг тасралтгүй явуулж байна.

- Өсвөрийн шигшээ багийн багш дасгалжуулагчдын жилийн төлөвлөгөөг, уралдаан тэмцээнд оролцох хуваарь, тухайн жилд зарцуулах төсвийн саналыг авч, батлагдсан төлөвлөгөөний дагуу бэлтгэл сургуулилтад хамруулах ажлыг зохион байгуулдаг. Мөн нийт



шигшээ багуудын нэгдсэн төлөвлөгөөг гарган батлууллаа. Өсвөрийн шигшээ багийн тоог спортын 15 төрөл болгон Засаг даргын захирамж гаргуулахаар төлөвлөнө ажиллаж байна.

Өсвөрийн шигшээ багийн 12 төрөлд нийт 1,000 гаруй тамирчин хүүхэд хичээллэж байгаа бөгөөд үүнээс 192 тамирчинг Дүүргийн аварга шалгаруулах тэмцээн болон бусад шатны уралдаан тэмцээнээс сонгон шалгаруулж бүртгэн авч хичээллэж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар Өсвөр үе, залуучуудын дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 4 төрлөөр явуулж нийт 77 сургуулийн 488 сурагчид хамрагдсан байна. Баянзүрх дүүргийн өсвөрийн шигшээ багийн тамирчид хотын аварга шалгаруулах тэмцээнд 1, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож 13 алт, 7 мөнгө, 10 хүрэл нийт 30 медаль хүртлээ.

2.4.Хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн, санал зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал, 2.6.Үндсэн чиг үүргийн биелэлт, үр дүнд дотоод аудит, хяналт эсвэл хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх, үг ажлын дүгнэлтийг үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлсэн байдал

- Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороонд хийгдсэн Дотоод аудитын албаны хяналт шалгалтын санал, зөвлөмж

Баянзүрх дүүргийн Дотоод аудитын албаны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, дүүргийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдөр баталсан 13 тоот удирдамжийн дагуу 2022 оны 08 дугаар сарын 08- 25-ны өдрийг хүртэл хугацаанд Биеийн тамир спортын хорооны 2020, 2021, 2022 оны хагас жилийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн дагуу эсэхэд хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн аудитын дүгнэлтээр “Сайжруулах шаардлагатай” хэмээн Биеийн тамир, спортын хороонд хүргүүлсэн.

1. Баянзүрх дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/74 тоот захирамжаар Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны бүтэц орон тоог ЗГТА БТСУХ-ны даргын 2022 оны 1/52 албан тоотыг үндэслэн батлахдаа алдаатай захирамж гарсан байна.
2. Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээг хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, ажилтан, мэргэжилтнүүдэд танилцуулан ажиллаж байгаагүй байна.
3. 2021, 2022 оны 2 дугаар улирлын баримтыг шалгахад анхан шатны баримтын бүрдэл дутуу, и-баримтгүй 7,674,046 төгрөгийн ажил, гүйлгээг санхүүгийн тайланд тусгасан байна.
4. Тус байгууллага нь албан хаагчдад цалин бодож олгохдоо эрх бүхий байгууллагаас баталсан журам, заавар, зөвлөмж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу олгосон байдал хангалтгүй .
5. 2020 онд холбогдох тэмцээн уралдаан зохион байгуулахдаа шагналт байр эзэлсэн тамирчдын шагналаас 310 000 төгрөгийн ХХОАТ-ийг суутган авсан боловч 2020 оны 4-р улирлын ТТ-11 татварын тайланд тайлагнаагүй байна.

Тайлангаар илэрсэн асуудалд өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Баянзүрх дүүргийн Дотоод аудитын албанд албан бичгээр ирүүлнэ үү.

- Дотоод аудитын албанаас ирүүлсэн, санал зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал

1. Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/74 тоот захирамжийг 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/726 дугаар захирамжаар хүчингүйд тооцож шинэ бүтэц орон тоо батлуулав.
2. Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчилсэн хууль тогтоомжийн дагуу 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс ажилтан, албан хаагчид бүгд хамтран баталж мөрдүүлж эхэлсэн. Ажилтан албан хаагчдын танилцсан баталгааг гарын үсгээр



баталгаажуулан хүргүүлэв.

3. 2021, 2022 оны 2 дугаар улирлын 7,674,046 төгрөгийн и-баримтыг хавсаргав.
4. Байгууллагаас баталсан журам, заавар, зөвлөмж, байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээг мөрдөж ажиллаж байна.
5. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж байна.

2.7. Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал

- Биеийн тамир, спортын хорооны Хүний нөөц, архив, бичиг хэргийн ажилтан EDOC албан хэрэг хөтлөлтийн системийг өдөр бүр шалгаж, шилжүүлэлт, шийдвэрлэлт цаг тухай бүрт хийгдэж байна. 2022 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар <https://edoc.ulaanbaatar.mn> систем буюу цахим хаягаар ирсэн албан бичиг -137, үүнээс хариутай 18 байгаагаас шийдвэрлэлт - 100 хувьтай, 143 албан бичгийг албан байгууллага, аж ахуйн нэгжид явуулсан байна.

2.8. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

- Байгууллагын хэмжээнд 2022 онд өргөдөл, гомдол ирээгүй байна.

2.9. Байгууллагын үйл ажиллагаанд дотоод удирдлагын программ нэвтрүүлсэн байдал, үр дүн

- Байгууллагын үйл ажиллагаанд дотоод удирдлагын erp.ulaanbaatar.mn, ХНУМТ-ийг хөтлөн, тухай бүр өөрчлөлтийг бүртгэн ажиллаж байна. EDOC албан хэрэг хөтлөлтийн системийг өдөр бүр шалгаж, шилжүүлэлт, шийдвэрлэлт цаг тухай бүрт хийгдэж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар <https://edoc.ulaanbaatar.mn> систем буюу цахим хаягаар ирсэн албан бичиг -137, үүнээс хариутай 18 байгаагаас шийдвэрлэлт - 100 хувьтай, 143 албан бичгийг албан байгууллага, аж ахуйн нэгжид явуулсан байна.
- Ажлын хэсэг, хурал, уулзалт, үүрэг далгавар системийн хэрэгжилт тухай бүр хийгдэж байна. Системд одоогоор Удирдах ажилтнуудын 13, 14, 16 дугаар шуурхай зөвөлгөөний үүрэг даалгаврын биелэлт орсон бөгөөд шийдвэрлэлт - 100 хувьтай байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

3.1. Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО ХЭРЭГЖИЛТ

- 2022 онд Манай байгууллага нь шинэ бүтэц өөрчлөлтийн хүрээнд Дарга, Нягтлан бодогч, Спортын хэлтсийн дарга, Биеийн тамирын хэлтсийн дарга, Тогтоол шийдвэрийн биелэлт, хяналт, шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан Ахлах мэргэжилтэн, Өсвөрийн шигшээ баг, хүүхдийн спортын асуудал хариуцсан мэргэжилтэн, Спортын тэмцээн, наадам, спортын холбоодын асуудал хариуцсан мэргэжилтэн, Биеийн тамирын статистик, цахим мэдээллийн сангийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Спортын сургалт-дасгалжуулалтын бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Хүний нөөц, бичиг хэрэг, архивын асуудал хариуцсан мэргэжилтэн, Ахмад, хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн, Биеийн тамирын арга зүйчийн асуудал хариуцсан мэргэжилтэн 12 мэргэжилтэн, Нярав, Үйлчлэгчийн ажлыг хавсран гүйцэтгэж, Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтний 1 сул орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.
- Байгууллагад бүтцийн өөрчлөлт явагдсантай холбоотой ажилтан, албан хаагчдын төрийн албаны ангилал, зэрэглэл, цалин урамшуулал, өөрчлөлтийг



тухай бүрт нь <https://hr.csc.gov.mn>, <https://erp.ulaanbaatar.mn> сайтад шивж оруулан ажиллаж байна.

- Тус байгууллагын ХАСХОМ гаргах 1 албан тушаалтан 2022 оны 02 дугаар сарын 15-с өмнө мэдүүлэг болон тайлангаа гарган НЗДТГ-н ТЗУХ-т хүргүүлж ажилласан.
- Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2021-2023 боловсруулан удирдлагаар батлуулан хэрэгжүүлтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 2022 оны байдлаар ажилтан, албан хаагчдыг доорх сургалтуудад хамруулаад байна.

№	Сургалт	Хэзээ	Хамрагдсан ажилтан, албан хаагчдын тоо
1	2	3	4
1.	e-doc албан хэрэг хөтлөлтийн цахим системийн сургалт	2022.02.25	1
2.	Egr системийн хөтлөлтийн цахим системийн сургалт	2022.03.01	1
3.	ХНУМТ системийн хөтлөлтийн цахим системийн сургалт	2022.03.21	1
4.	МБАТС XV наадмын цахим бүртгэлийн сургалт (цахим)	2022.03.20	1
5.	ТАЗ-ийн Төрийн албан хаагчийн ёс зүй харилцаа хандлагын өөрчлөлт бүтээмжийг дэмжих сургалт	2022.03.31	9
6.	“Нийслэл-110” Менторшип хөтөлбөр	2022.04.13-05.10	А.Аззаяа
7.	Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудын анхаарах асуудал	2022.04.14	2
8.	УБ марафоны админ хариуцсан мэргэжилтнүүдийн Hiraу app хэрхэн бүртгэл хийх тухай сургалт	2022.04.15	3
9.	Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагуудын ажил танилцуулах, туршлага солилцох өдрийн сургалт	2022.04.15	9
10.	Дэлхийн бөхийн холбооны шүүгчийн сургалт	2022.04.18-24	Ю.Батсайхан
11.	“УБ марафон-2022” олон улсын гүйлтийн бүртгэл, админ хариуцсан ажилтнуудын сургалт	2022.04.25	2
1	2	3	4
12.	Төрийн жинхэнэ албан хаагчдын шалгалтад бэлтгэх сургалт	2022.05.12	9
13.	Үндэсний VII наадмын цахим сургалт	2022.05.15	1
14.	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022.01.01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан сургалт	2022.05.16	13
15.	ТАЗ-ийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих сургалт	2022.05.19	9
16.	Улаанбаатар хотын хаягжуулалт, Хаягийн хэрэглээ сургалт	2022.06.16	1
17.	Үндэсний VII наадмын цахим сургалт	2022.06.23	1



18.	Допингийн эсрэг үйл ажиллагааг сайжруулах, бэхжүүлэх сургалт	2022.06.22-24	9
19.	Архив, албан хэрэг хөтлөлтийн 10 хоногийн онлайн сертификат сургалт	2022.06.25-07.05	А.Азжая
20.	Архив, албан хэрэг хөтлөлтийн edoc системд эхний хагас жилд үүссэн зөрчлийн дэлгэрэнгүй, түүнд анхаарах асуудал	2022.06.29	1
21.	МБАТС XV наадмын цахим бүртгэлийн сургалт(танхимаар)	2022.08.22	2
22.	Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам	2022.09.13	1
23.	Оюуны витамин сургалт	2022.09.20	5
24.	“Хөгжөөн дэмжигчийн спорт” сургалт	2022.10.20-11.04	1
25.	Монгол бичигтэн-2025 сургалт	2022.10.24	1
26.	“Мэдээ, тайлан, үүрэг даалгаврын биелэлт ирүүлэх, өргөдөл гомдол, албан бичгийн шийдвэрлэлтэд анхаарах асуудал” сургалт	2022.10.27	1
27.	БЗД-ийн Байгууллагуудын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн анхдугаар зөвлөгөөн	2022.11.01	5
28.	Олимпын зөвлөлийн арга зүйчийн сургалт	2022.11.02-05	1
29.	Нийслэлийн Баянзүрх дүүргийн Спортын удирдах ажилтны уулзалт-сургалт	2022.11.16	10
30.	Биеийн тамир спортын хороо, аймаг нийслэл, дүүргийн биеийн тамир спортын газар, хорооны албан хаагчдад зориулсан цахим сургалт (Жендерийн тэгш байдал, хувь хүний хөгжлийн талаарх мэдлэг, мэдээлэл өгөх)	2022.11.23	9

АРХИВ АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, АЛБАН БИЧИГ, ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭН АЖИЛЛАСАН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ

- Байгууллагын албан хаагчид <https://erp.ulaanbaatar.mn> болон <https://edoc.ulaanbaatar.mn> албан хэрэг хөтлөлтийн програмыг тогтмол ашиглан ажиллаж байна.
- 2022 оны 11 дүгээр сарын 22-ны байдлаар албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн <https://edoc.ulaanbaatar.mn> систем буюу цахим хаягаар ирсэн албан бичиг 137, үүнээс хариутай 18 байгаагаас шийдвэрлэлт - 100 хувьтай, 143 албан бичгийг албан байгууллага, аж ахуйн нэгжид явуулсан байна.
- Байгууллагын даргын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр буюу А тушаал 70, хүний нөөцийн чиглэлээр буюу Б тушаал 50 гаргаж, үйл ажиллагааг бүрэн зохион байгуулж тушаалын хэрэгжилт 100%-тай хэрэгжсэн байна.
- Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн 2021 оны архивын баримтыг цахим архивын програмд шилжүүлсэн.
- 2021 онд үүссэн захирамжлалын баримт бичиг байгууллагын даргын А тушаал 25, Б тушаал 14 ширхэгийг архивын цахим програмд шивж оруулсан байна.
- Мөн 2021 онд үүссэн байнга хадгалах 12 ширхэг, түр хадгалах 19 ширхэг, 70 жил хадгалах 3 ширхэг хадгаламжийн нэгжийг тус тус шалган хүлээн авч, байгууллагын дэргэдэх БНШК-ын хурлаар оруулан баталгаажуулан архивт нөхөн бүрдүүлэлт хийсэн байна.
- Байгууллагын нэр дээр Өргөдөл, гомдол бүртгэгдээгүй бөгөөд шийдвэрлэлт 0 хувь байна.



Хүний нөөцийн бодлого

- Байгууллагад бүтцийн өөрчлөлт явагдсантай холбоотой ажилтан, албан хаагчдын төрийн албаны ангилал, зэрэглэл, цалин урамшуулал, өөрчлөлтийг тухай бүрт нь <https://hr.csc.gov.mn> ,<https://erp.ulaanbaatar.mn> сайтад шивж оруулан ажиллаж байна.
- Тус байгууллагын ХАСХОМ гаргах 1 албан тушаалтан 2022 оны 02 дугаар сарын 15-с өмнө мэдүүлэг болон тайлангаа гарган НЗДТГ-н ТЗУХ-т хүргүүлж ажилласан.
- Байгууллагын мэргэжилтэн Б.Мөнхзаяа ЗГТА-удирдлагын академын магистрантаар суралцаж төгслөө, Мэргэжилтэн А.Аззаяа НЗДТГ, мөн тус газрын Хүний нөөцийн хөгжлийн төв, Азийн сангийн Хотын засаглалыг сайжруулах төслийн хамтран зохион байгуулж буй “Нийслэл-110” менторшип хөтөлбөрийн нэгдүгээр шатанд амжилттай оролцлоо, Бичиг хэргийн шинэчилсэн стандарт, архив, албан хэрэг хөтөлөлтийн сургалтад хамрагдав, Спортын хэлтсийн дарга Ю.Батсайхан ОУ-н шүүгчийн сургалтад хамрагдан түвшингөө ахиулав.

Зорилт	№	Үйл ажиллагаа		Зорилтот түвшин /тоо, хэмжээ, хувь/	Хүрсэн түвшин /хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ/	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр /мян.төг/	Тайлбар
1. Хүний нөөцийг чадваржуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоодын сургалтын тоо	30	30		Холбогдох байгууллагуудаас зохион байгуулсан 30 удаагийн цахим болон танхимын сургалтад 13 албан хаагчийг хамруулсан байна. Төрийн албаны Ерөнхий шалгалтанд бэлтгэн хамруулж 6 албан хаагч тэнцсэн.
			Албан хаагчдын хамрагдсан байдал	13	13		
			Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал	1	1		
2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	14	9		Тус байгууллага Дарга, 13 албан хаагчтай бөгөөд тэдгээрийн 9 албан хаагч нь 3 ба түүнээс дээш жил ажилласан. Ахлах мэргэжилтэн Б.Мөнхзаяа ЗГТА-удирдлагын академын магистрантаар суралцаж төгслөө.	



Хэсгийн дундаж: 50%							
2. Ал ба н хаа гчд ийн ний гми йн бат алг ааг хан гах	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	13	13	МУЗГ-н 2022 оны 107 дугаар тогтоолыг хэрэгжүүлж байна.	
			Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах	13	10	Ур чадварын нэмэгдэл 13 , спортын цол зэргийн нэмэгдэл 10, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 5 албан хаагч авч байна.	
	4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	13	13	Албан хаагчдын ажиллах нөхцөл байдлыг дүүргийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслийн удирдагч Ц.Алтанзагаст танилцуулж 2021 онд дэмжлэг хүсэлт гаргаж энэ онд ажилтан, албан хаагчдад 2 шинэ суурин иж бүрэн компьютер хүлээлгэн өгч, 7 сараас түрээсийн байрны төлбөр төсвийн тодотголд сууж орж ирсэн тул ажиллах таатай орчин нөхцөлөө бүрдүүлэн ажиллаж байна.	
			Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	13	13	Бүрэн авч байна.	
	5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	13	10	Ажилтан албан хаагчдыг эрт илрүүлэгт хамруулан 8 төрлийн үзлэг оношлогоо хийлгэж, ерөнхий эмчийн тайлбар дүгнэлт гаргуулаад байна.	
			Албан хаагчдын хамрагдалт	13	10		
	Хэсгийн дундаж: 50%						
	Үнэлгээний дундаж хувь: 100%						



3.2.Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлтийн байдал, үр дүн

Байгууллагын өмч, санхүүгийн талаар

- Улсын төсвөөр 2022 онд нийтдээ 448 287 700 төгрөг батлагдсан ба эхний 11 сарын байдлаар 385 050 900 төгрөг санхүүжихээр батлагдсан байна.
- Орон нутгийн төсвөөс 2022 онд нийтдээ 237 584 800 төгрөг батлагдсан ба эхний 11 сарын байдлаар 96 309 700 төгрөг санхүүжихээр батлагдсан байна.
- **Үүнээс:**

Биеийн тамир, спортын арга хэмжээнд 20 960 200 төгрөг

Нийтийн биеийн тамирын арга хэмжээнд 132 835 000 төгрөг

Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулалд 164 963 800 төгрөг

Ажил олгогчоос нийгмийн даатгалын даатгалд төлөх шимтгэл 20 620 600 төгрөг

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 21 672 000 төгрөг

Хангамж, бараа материалын зардал 7 194 300

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 2 902 000

Эд хогшил, урсгал засварын зардалд 4 000 000

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 1 100 000

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 32 358 000

Бараа үйлчилгээний бусад зардал 1 465 000

- Байгууллагын мэдээллийн самбарт байршуулах, шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу шилэн дансны <https://shilendans.gov.mn>, <https://shilendans.ub.gov.mn> сайтуудад байгууллагын 2022 оны жилийн төсөв, 2021 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, дараа оны төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг мэдээллийг самбарт байршуулсан.
- Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, ашгийн орлогын, албан татварын тооцоо тайланг цаг хугацаанд нь гарган ажиллаж байна.
- Байгууллагын төсвийг нэмэгдүүлэх, уралдаан, тэмцээн, арга хэмжээний үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудтай арга хэмжээг удирдлага, зохион байгуулалт, хөрөнгө, санхүү, материаллаг баазын хувьд хамтран ажиллаж байна.
- Мөн үргүй зардлыг багасгах, төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтанд тавих хяналтыг өндөржүүлж, төсвийн сахилгыг мөрдлөгө болгон ажиллаж байна.



Үйл ажиллагааны ил тод байдал, шилэн данс

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулан тухай бүр шинэчлэх.	Биеийн тамир спортын хорооноос зохион байгуулах бүхий л арга хэмжээний байгууллагын даргаар батлагдсан удирдамж, заавар, холбогдох мэдээ мэдээллийг байгууллагын www.facebook.com/Спорт_хороо_Баянзүрх нүүр хуудас болон https://bzd.sport.gov.mn вэйб сайтад байршуулдаг ба тус хуудаснаас бүх байгууллагууд болон хороод мэдээллээ бүрэн авч хамтран ажиллаж байна. Байгууллагын сайт нь Нүүр хуудас, Спортын хороо, Хууль эрх зүй, Цаг үеийн мэдээ (Онцлох мэдээ, тэмцээний заавар, удирдамж, фото мэдээ, видео, зөвлөгөө, нийтлэл), Ил тод байдал (Шилэн данс, үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдал, хөрөнгө оруулалт, төсөв, санхүү, тендер, анкет, маягт, өргөдөл, гомдол, цол зэрэг), Өсвөрийн шигшээ баг (дасгалжуулагчид, тамирчид, тайлан), Холбоо барих (фб хуудас, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, байршил), МБАТС-ын XV наадам гэсэн цэснүүдээс бүрдэж байгаа бөгөөд 2022 онд 220 мэдээ мэдээллийг нийтэлж 13,000 гаран хандалт авсан байна.	100%
Хоёр. Шилэн данс			
1.	Шилэн дансны мэдээлэл оруулах	Монгол Улсын Шилэн дансны тухай хууль тогтоомжид заасан хуваарийн дагуу 3 дугаар улиралд оруулбал зохих мэдээллүүдийг цаг хугацаанд нь оруулсан. Үүнд: 1. “Бүтэн жилээр оруулах мэдээлэл”-ээс: - 01-р сарын 10-ны дотор оруулах шаардлагатай “Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл”, “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө” бүлгүүдийн “ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТЕНДЕР, ХУДАЛДАН АВАЛТ” төрөлд “ОРУУЛАХ МЭДЭЭЛЭЛ БАЙХГҮЙ” гэсэн мэдээлэл оруулсан. - 01-р сарын 16-ны дотор оруулах шаардлагатай “Байгууллагын батлагдсан төсөв” бүлгийн “ТӨСӨВ/ГҮЙЦЭТГЭЛ” төрөлд 225 988 .5 мянган төгрөгийн төсвийн мэдээлэл оруулсан. 2. “Улирал бүр оруулах мэдээлэл”-ээс: - “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт” бүлгийн “ТӨСӨВ/ГҮЙЦЭТГЭЛ” төрөлд 3. “Сар бүр оруулах мэдээлэл”-ээс:	100%



	<p>- “Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл” бүлгийн “ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТЕНДЕР, ХУДАЛДАН АВАЛТ” төрөлд, “Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт” бүлгийн “БУСАД” төрөлд 1, 2,3,4,5,6,7,8,9,10, дугаар саруудад мэдээлэл оруулсан.</p> <p>- “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт” бүлгийн “ТӨСӨВ/ГҮЙЦЭТГЭЛ” төрөлд 1, 2,3,4,5 ,6,7,8,9,10 дугаар саруудын мэдээг заасан хуваарийн дагуу дараа сарын 08-ны дотор оруулсан.</p> <p>“Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн жилийн батлагдсан төсөвт 685 872 500 төг, үүнээс 2022 оны 01 дүгээр сард улсын төсвөөс санхүүжилт орж ирээгүй тул</p> <p>1-р сарын тайлант үед улсын нутгийн төсвөөс 38 126 100 төг, үүнээс: гүйцэтгэл 8 010 751 төг, хэмнэлт 30 115 349 төг байна гэж 2022.02.08-ны дотор оруулсан.</p> <p>1-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 3 432 000 төг, үүнээс: гүйцэтгэл 0 төг, хэмнэлт 3 432 000 төг байна гэж 2022.02.08-ны дотор оруулсан.</p> <p>2-р сарын тайлант үед улсын нутгийн төсвөөс 69 438 200 төг, үүнээс: гүйцэтгэл 31 634 009,5 төг, хэмнэлт 37 804 190,5 төг байна гэж 2022.02.08-ны дотор оруулсан.</p> <p>2-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 7 864 000 төг, үүнээс: гүйцэтгэл 3 037 207,1 төг, хэмнэлт 4 826 792 ,9 төг байна гэж 2022.02.08-ны дотор оруулсан.</p> <p>3-р сарын тайлант үед улсын нутгийн төсвөөс 135 340 300 төг, үүнээс: гүйцэтгэл 96 724 456 төг, хэмнэлт 38 615 844 төг байна гэж 2022.04.08-ны дотор оруулсан.</p> <p>3-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 12 296 000 төг, үүнээс: гүйцэтгэл 4 862 224 ,22 төг, хэмнэлт 7 433 775 ,78 төг байна гэж 2022.04.08-ны дотор оруулсан.</p> <p>4-р сарын тайлант үед улсын нутгийн төсвөөс 137 876 400 төг, үүнээс: гүйцэтгэл 112 208 966 төг, хэмнэлт 25 667 434 төг байна гэж 2022.05.08-ны дотор оруулсан.</p> <p>4-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 15 728 000 төг, үүнээс: гүйцэтгэл 6 594 607 ,5 төг, хэмнэлт 9 133 392 ,5 төг байна гэж 2022.05.08-ны дотор оруулсан.</p>	
--	---	--



	<p>5-р сарын тайлант үед улсын нутгийн төсвөөс 204 828 500 төг, үүнээс: гүйцэтгэл 170 596 968 төг, хэмнэлт 34 231 532 төг байна гэж 2022.06.08-ны дотор оруулсан.</p> <p>5-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 21 160 000 төг, үүнээс: гүйцэтгэл 8 141 334 ,55 төг, хэмнэлт 13 018 665 ,45 төг байна гэж 2022.06.08-ны дотор оруулсан.</p> <p>6-р сарын тайлант үед улсын нутгийн төсвөөс 240 172 600 төг, үүнээс: гүйцэтгэл 201 895 593.5 төг, хэмнэлт 38 277 006.5 төг байна гэж 2022.07.08-ны дотор оруулсан.</p> <p>6-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 23 509 700 төг, үүнээс: гүйцэтгэл 9 612 811 төг, хэмнэлт 13 896 889 төг байна гэж 2022.07.08-ны дотор оруулсан.</p> <p>7-р сарын тайлант үед улсын нутгийн төсвөөс 274 866 700 төг, үүнээс: гүйцэтгэл 227 723 711 төг, хэмнэлт 47 142 989.5 төг байна гэж 2022.08.08-ны дотор оруулсан.</p> <p>7-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 39 109 700 төг, үүнээс: гүйцэтгэл 12 691 981 төг, хэмнэлт 26 417 719 төг байна гэж 2022.08.08-ны дотор оруулсан.</p> <p>8-р сарын тайлант үед улсын нутгийн төсвөөс 312 536 000 төг, үүнээс: гүйцэтгэл 264 988 778 төг, хэмнэлт 47 547 220 төг байна гэж 2022.09.08-ны дотор оруулсан.</p> <p>8-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 54 709 700 төг, үүнээс: гүйцэтгэл 16 664 821 төг, хэмнэлт 38 044 879 төг байна гэж 2022.09.08-ны дотор оруулсан.</p> <p>9-р сарын тайлант үед улсын нутгийн төсвөөс 334 230 100 төг, үүнээс: гүйцэтгэл 298 984 304.5 төг, хэмнэлт 35 245 795.5 төг байна гэж 2022.10.08-ны дотор оруулсан.</p> <p>9-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 96 309 700 төг, үүнээс: гүйцэтгэл 19 364 821 төг, хэмнэлт 76 944 879 төг байна гэж 2022.10.08-ны дотор оруулсан.</p> <p>10-р сарын тайлант үед улсын нутгийн төсвөөс 369 394 200 төг, үүнээс: гүйцэтгэл 327 139 440.44 төг, хэмнэлт 42 254 759.56 төг байна гэж 2022.11.08-ны дотор оруулсан.</p> <p>10-р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 96 309 700 төг, үүнээс: гүйцэтгэл 22 064 821 төг, хэмнэлт 74 244 879 төг байна гэж 2022.11.08-ны дотор оруулсан.</p> <p>11-р сарын тайлант үед улсын нутгийн төсвөөс 396 215 900 төг, үүнээс: гүйцэтгэл 350 765 816 төг, хэмнэлт 34 418 082.5 төг байна гэж 2022.12.08-ны дотор оруулсан.</p>	
--	--	--



		<p>11 -р сарын тайлант үед орон нутгийн төсвөөс 96 309 700 төг, үүнээс: гүйцэтгэл 24 764 821 хэмнэлт 71 544 879 төг байна гэж 2022.12.08-ны дотор оруулсан.</p> <p>4. “Тухай бүрт нь оруулах мэдээлэл”-ээс: - “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл”, “Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт” болон “Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн” бүлгийн “БУСАД” төрөлд 1,2,3 дугаар саруудад “ОРУУЛАХ МЭДЭЭЛЭЛ БАЙХГҮЙ” гэсэн мэдээлэл оруулсан.</p> <p>- “Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт” бүлгийн “ТӨСӨВ / ГҮЙЦЭТГЭЛ” төрөлд 1,2,3,4,5,6,7,8,9,10,11 дугаар сарын мэдээг заасан хуваарийн дагуу дараа сарын 08-ны дотор оруулсан.</p> <p>- “Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл” бүлгийн “Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт” төрөлд 1,2,3,4,5,6,7,8,9,10, дугаар саруудад “БАЙХГҮЙ” гэсэн мэдээлэл оруулсан.</p> <p>- “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” бүлгийн “БУСАД” төрөлд 1,2,3,4,5,6,7,8,9,10 дугаар саруудад “ оруулах мэдээлэл байхгүй гэж холбогдох мэдээллийг оруулсан.</p> <p>- “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ” бүлгийн “ТӨСӨВ/ГҮЙЦЭТГЭЛ” төрөлд</p> <ul style="list-style-type: none">• 1 дүгээр сард нийт 34 694 100 төгрөгийн орлогын;• 2 дугаар сард 34 744 100 төгрөгийн орлогын;• 3 дугаар сард нийт 34 544 100 төгрөгийн орлогын;• 4 дүгээр сард 34 394 100 төгрөгийн орлогын;• 5 дугаар сард нийт 91 384 100 төгрөгийн орлогын;• 6 дугаар сард нийт 38 193 800 төгрөгийн орлогын;• 7 дугаар сард нийт 50 294 100 төгрөгийн орлогын;• 8 дугаар сард нийт 53 269 300 төгрөгийн орлогын;	
--	--	---	--



		<ul style="list-style-type: none">• 9 дүгээр сард нийт 63 294 100 төгрөгийн орлогын;• 10 дугаар сард нийт 35 164 100 төгрөгийн орлогын;• 11дүгээр сард нийт 35 913 100 төгрөгийн орлогын; <p>мэдээллийг тус тус оруулсан</p>	
Үнэлгээний дундаж хувь 100%			

ХЯНАСАН: БИЕЙН ТАМИР СПОРТЫН

ХОРООНЫ ДАРГА

Д.ОТГОНСҮРЭН

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН: БИЕЙН ТАМИР СПОРТЫН

ХОРООНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.МӨНХЗАЯА



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРОО